

Шилүүстэй сумын төсөвт байгууллагуудын 2017 оны үйл ажиллагааны үр дүн

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



Шилүүстэй сумын төсөвт байгууллагуудын 2017 оны үйл ажиллагааны үр дүн

Орон нутгийн татварын орлогын давсан хэсгийг ард иргэдэд үр өгөөжөө өгөх үр дүнтэй арга хэмжээнд зарцуулах нь зүйтэй байна

Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 99014227, 98825995, 89330330, 90066888, 99054581 дугаарын утсаар харилцана уу

ХАЯГ: Завхан аймгийн Аудитын газар Улиастай сум, Жинст багийн Нутгийн захиргааны ордон 309,310 тоот өрөө

Гүйцэтгэсэн :

Ахлах аудитор

Аудитор Б.Дагвасүрэн
Б.Жалбаа
Б.Мөнхнасан

Хянасан: Дарга, Тэргүүлэх аудитор
Л.Уламбаяр

2018.06.28

Шилүүстэй сумын төсөвт байгууллагуудын 2017 оны үйл
ажиллагааны үр дүн

АГУУЛГА

➤ Товчилсон үгийн тайлбар.....	3
➤ Аудит хийх үндэслэл, аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй..	4
➤ Ерөнхий мэдээлэл	5
➤ Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр нь аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх аймгийн үндсэн чиглэлтэй уялдсан байна.	6- 14
➤ Орон нутгийн татварын орлогын давсан хэсгийг ард иргэдэд үр өгөөжөө өгөх үр дүнтэй арга хэмжээнд зарцуулах шаардлагатай байна.....	15- 17
➤ ОНХС-ийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.	17-18
➤ Албан шаардлагын биелэлтийг хангуулж ажилласан байна.	18-19
➤ Төсөвт байгууллагуудын үйл ажиллагааны үр дүн	
❖ ИТХ-ын үйл ажиллагааны үр дүн.....	19-20
❖ Засаг даргын тамгын газрын үйл ажиллагааны үр дүн.....	21-22
❖ Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны үр дүн.....	23-26
❖ Хүүхдийн цэцэрлэгийн үйл ажиллагааны үр дүн.....	27-28
❖ Соёлын төвийн үйл ажиллагааны үр дүн.....	29-32
❖ Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны үр дүн.....	33-36
➤ Зөвлөмж	
❖ ИТХ.....	37
❖ ЗДТГ.....	38
❖ Ерөнхий боловсролын сургууль.....	39
❖ Хүүхдийн цэцэрлэг.....	40
❖ Соёлын төв.....	41
❖ Эрүүл мэндийн төв.....	42

Шилүүстэй сумын төсөвт байгууллагуудын 2017 оны үйл ажиллагааны үр дүн

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

- ИТХ - Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
- АИТХ - Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
- ЗДТГ - Засаг даргын тамгын газар
- ИТХХ - Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хуралдаан
- ОНХС - Орон нутгийн хөгжлийн сан
- БИНХ - Багийн Иргэдийн Нийтийн Хурал
- ҮАГ - Үндэсний Аудитын Газар
- ЗГ - Засгийн газар
- АДБОУС - Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
- УТХО - Улсын Төсвийн Хөрөнгө Оруулалт
- ХЭДС - Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
- ЖДҮДС - Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан
- БНХАУ - Бүгд Найрамдах Хятад Ард Улс
- БӨХ - Байгууллагын өөрийн хөрөнгө
- ТХ - Төсөл хөтөлбөр
- ОНЗС - Орон нутгийн замын сан
- БХНСАХЗ - Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардал
- СХС - Сум хөгжүүлэх сан
- НД - Нийгмийн даатгалын
- ЕБС - Ерөнхий бэлтгэлийн сургууль

Шилүүстэй сумын төсөвт байгууллагуудын 2017 оны үйл ажиллагааны үр дүн

1.Аудитын үндэслэл

Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2018 оны А/06 дугаар тушаалаар батлагдсан “ Үндэсний аудитын газрын 2018 онд гүйцэтгэх аудитын сэдвийн төлөвлөгөө”-г үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

2.Аудитын зорилт:

“Шилүүстэй сумын төсөвт байгууллагуудын 2017 оны үйл ажиллагааны үр дүн”-д аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийв. Үүнд:

- Сумын засаг даргын мөрийн хөтөлбөр болон эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт, үр дүн
- Орон нутгийн татварын орлого, ОНХС, СХС болон төсөвт байгууллагуудын орлого бүрдүүлэлт, зарцуулалтын үр дүн
- Хөрөнгө оруулалт болон хөтөлбөр арга хэмжээний үр дүн

3.Хамарсан хүрээ

Аудитад Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийг дагаж мөрдөж эхэлсэн 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш боловсруулан баталж, хэрэгжиж байгаа хөгжлийн бодлогын баримт бичгийн хүрээнд сумын ИТХ, Засаг дарга түүний харьяа агентлаг, байгууллага холбогдох ажилтнуудыг хамруулан сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, үндсэн чиглэлийн хэрэгжилтийн ажлын үр дүн, төсөвт байгууллагуудын 2017 оны үйл ажиллагааг хамруулан шалгалаа.

4.Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд Гүйцэтгэлийн аудитын удирдамж АДБОУС 3000-3100, гүйцэтгэлийн аудитын журмыг баримтлан шалгагдагч холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа авах, байгууллагын санхүүгийн тайлан, бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийж, аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

5.Аудитад ашиглах шалгуур үзүүлэлтүүд

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашигласан.

- Төрийн Аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
- Боловсролын тухай хууль
- Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль

Шилүүстэй сумын төсөвт байгууллагуудын 2017 оны үйл ажиллагааны үр дүн

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Татварын тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- ТБОНӨХБАҮХАТухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Эрүүл мэндийн тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Холбогдох бусад хууль, журам эрхийн акт
- Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр
- Сумын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төлөвлөгөө, хэрэгжилт

6. Аудит хийх багийн бүрэлдэхүүн

Аудитыг дарга бөгөөд тэргүүлэх аудитор Л.Уламбаяр хянан удирдаж, аудитын менежер Г.Хашцэцэг аудитын үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Дагвасүрэн, Аудитор Б.Жалбаа, Б.Мөнхнасан нар аудитыг гүйцэтгэлээ.

7. Аудитын хугацаа

Аудитыг 2018 оны 06 сарын 01-нээс 2018 оны 07 сарын 05-ны дотор гүйцэтгэлээ.

Аудитын тайланд дэвшүүлсэн зорилт, хамарсан хүрээ, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмжөөс гадна шалгагдагч байгууллагын саналыг тусгав.

8. Аудитын тайлангийн бүтэц түүнд тусгагдах мэдээлэл хэлэлцүүлэх журам:

Аудитын тайлан нь ерөнхий зүйл, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж, холбогдох байгууллагын санал, бий болгосон үр өгөөж, акт баримтууд хавсралт хэсгүүдээс бүрдсэн. Аудитын тайлангийн төслийг сумын төсвийн ерөнхийлөн захирагч, төсөвт байгууллагуудын менежер нарт танилцуулан саналыг авч хуулийн дагуу тавигдсан саналыг тайланд тусган боловсруулж зөвлөлийн хуралд оруулан тайланг эцсийн байдлаар холбогдох албан тушаалтнуудад хүргүүлэв.

Аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Ерөнхий мэдээлэл:

СУМЫН ЭДИЙН ЗАСАГ НИЙГМИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ:

Тус сум 512 өрхийн 1820 хүн амтай, засаг захиргааны 4 багтайгаар иргэдэд төрийн үйлчилгээг хүргэж байна.

Шилүүстэй сумын төсөвт байгууллагуудын 2017 оны үйл ажиллагааны үр дүн

Сумын дүнгээр 2016 оны байдлаар 277 малтай өрх, 172 малчин өрх мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлж, газар тариалангийн үйлдвэрлэлээр жилийн хэрэгцээт төмс хүнсний ногоо болон чацарганыг сумандаа тариалж байна

2016 оны малын тооллогоор 21 мянгат малчин төрсөн бөгөөд хэтийн зорилгодоо тэмээн сүргийг тогтвортой өсгөх бодлого боловсруулах, бог малын хээлтүүлгийн асуудлыг баг сумын хэмжээнд анхаарах асуудал болгон ажиллаж байна.

Бүлэг.1. Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр нь аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх аймаг, сумын үндсэн чиглэлтэй уялдсан байна.

1.1 Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, үндсэн чиглэлийг төлөвлөж, боловсруулахдаа Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоолоор батлагдсан "Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам"-ыг мөрдөж ажиллаагүй байна.

Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг нягтлахад 4 бодлогын хүрээнд 37 зорилтын 141 асуудлыг хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр нь аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх 2017 оны үндсэн чиглэлд тусгагдсан сумын ажлууд СХС, ОНХС-ийн хөрөнгөөр 2016-2018 онд хэрэгжүүлэх ажлын санхүүжилт, өөрийн төсөвт тусгагдсан хөрөнгөөр хэрэгжих арга хэмжээнүүдийг тусгасан байна.

Тус сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулахдаа шаардлага хангасан судалгаа хийгээгүй, төлөвлөлтийн шатанд санхүүгийн эх үүсвэрийн үндэслэл, тооцоогүй, нийгэм эдийн засгийн үр дагавар, хүрэх үр дүнг үнэлэх, тодорхойлох арга аргачлал ашиглаагүй, хөтөлбөрийн төслийг боловсруулахдаа төлөвлөгөө гарган ажиллаагүй байна.

Хөтөлбөрийн боловсруулалтын байдлыг шалгахад дараах зөрчил дутагдлууд илэрлээ. Үүнд:

- Үйл ажиллагааны хөтөлбөрийн хувилбаруудад нөхцөл байдлын шинжилгээ хийж, тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлж, олон нийтээр хэлэлцүүлсэн асуудлуудыг эрэмбэлээгүй, хянаж боловсруулаагүй нь Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоолоор батлагдсан "Хөгжлийн бодлогын баримт бичиг

Шилүүстэй сумын төсөвт байгууллагуудын 2017 оны үйл ажиллагааны үр дүн

- боловсруулах нийтлэг журам"-ын 4 дүгээр хавсралтын дагуу гаргаж эерэг сөрөг нөлөөллүүдийг тооцож гаргаагүй байна.
- Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр үндсэн чиглэлийн төсөл боловсруулахдаа олон нийтийн оролцоо, ил тод байдлыг хангаж ажиллаагүй, хэлэлцүүлэг зохион байгуулаагүй нь Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 19.2¹ дахь заалтыг хэрэгжүүлээгүй байна.
 - Засаг даргын захирамжаар ажлын хэсгийг зохион байгуулж ажилласан боловч бүрэлдэхүүнд нь төрийн бус байгууллага, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, мэргэжлийн холбоодын төлөөллийг оролцуулаагүй, харин сум дахь төсөвт газруудын эрхлэгч, захирал, ТГ-ын мэргэжилтнүүдийг багтаасан нь “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”-ын 13 дахь заалтыг хэрэгжүүлээгүй байна.
 - Тус ажлын хэсэг нь төсөл боловсруулах ажлын төлөвлөгөөгүй, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаа болон хариуцан гүйцэтгэх, оролцох талын нэрсийн жагсаалтыг гаргаж ажиллаагүй, хөгжлийн бодлого төлөвлөлтөд баримтлах зарчмыг баримтлаагүй, төсөл боловсруулах үе шатны ажлуудыг нарийвчлан судлаагүйгээр, аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрөөс иш татан авсан нь Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-5.1.7² дахь заалт, “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”-ын 17-19 дэхь заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.
 - Арга хэмжээнүүдийн зорилго, зорилт, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтүүдийг тусгасан хэдий ч санхүүгийн эх үүсвэрийг судалгаанд үндэслэн тооцоогүй

1 19.2.Энэ хуулийн 19.1-д заасан хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулахдаа холбогдох төрийн захиргааны төв байгууллага болон нутгийн захиргааны байгууллага дараах хэлбэрээр хэлэлцүүлэг зохион байгуулж болно:

- 19.2.1.хууль ёсны эрх, ашиг сонирхол нь хөндөгдөх бүлгийн хүрээнд;
- 19.2.2.эрдэмтэн судлаач, шинжээч зэрэг мэргэшсэн хүрээнд;
- 19.2.3.тодорхой нутаг дэвсгэрийн хүрээнд;
- 19.2.4.төрийн болон төрийн бус байгууллагын хүрээнд.

2 5.1.Хөгжлийн бодлого төлөвлөлтөд дараах зарчмыг баримтална:

- 5.1.1.үндэсний язгуур эрх ашигт нийцсэн байх;
- 5.1.2.нэгдмэл, цогц, харилцан уялдаатай байх;
- 5.1.3.төрийн бодлогын залгамж чанарыг хадгалсан байх;
- 5.1.4.судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх;
- 5.1.5.нөөц бололцоонд үндэслэсэн байх;
- 5.1.6.ил тод, нээлттэй байх;
- 5.1.7.олон нийтийн оролцоог хангасан байх.

Шилүүстэй сумын төсөвт байгууллагуудын 2017 оны үйл ажиллагааны үр дүн

- ИТХ-ын ажлын албанд төслийг хүлээлгэн өгөхдөө хавсралт маягтуудыг хөтөлдөггүй, санхүү албанаас зөвшөөрөл авалгүй шууд хурлаар хэлэлцүүлж байгаа нь “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”-ын 31 дэх заалтай нийцэхгүй байна.

Хөтөлбөрийг боловсруулах ажлын хэсэг нь цуглуулсан мэдээллээ боловсруулах, ач холбогдлоор нь үнэлэх зорилгоор иргэдээс гарсан санал шүүмжийг судлан нягтлаж, аймгийн хөгжлийн тэргүүлэх чиглэл болон давуу, сул талуудыг тодорхойлоогүй байна.

Үйл ажиллагааны хөтөлбөрийн хувилбаруудад нөхцөл байдлын шинжилгээ хийж, тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлж, олон нийтээр хэлэлцүүлсэн зорилтуудаа Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоолоор батлагдсан "Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам"-ын 4 дүгээр хавсралтын дагуу гаргаж эерэг сөрөг нөлөөллүүдийг тооцож гаргаагүй байна.

Үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулахдаа өмнөх жилүүдийн төлөвлөгөө, үндсэн чиглэл сумын төсөвт байгууллагуудын жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, ОНХС, СХС-ийн 2017-2018 онуудад хийгдэх ажлууд болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг үндэслэн боловсруулсан гэж дүгнэх үндэстэй байна.

1.2 Сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн зорилтуудын санхүүгийн тооцооллыг бодит тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөөгүй байна

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1³.17.2⁴ дугаар зүйлд заасны дагуу холбогдох тоон болон чанарын мэдээлэлд дүн шинжилгээ хийж асуудлыг шийдвэрлэх арга замыг тодорхойлж, гарах үр дүн, үр нөлөөг тооцоогүй байна. Мөн хуулийн 18 дугаар зүйлийн 18.1⁵, 18.2⁶ -т заасны дагуу дунд богино хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн бодлогын баримт бичгийн төсөв, санхүүгийн тооцоолол, эх үүсвэрийг Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журмын 7 дугаар хавсралтаар зорилт бүрээр гаргаагүй байна.

ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТ БҮРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ШААРДЛАГАТАЙ ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ, САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭРИЙН ТӨСӨӨЛӨЛ ТООЦОО

³ 17.1.1.хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах үндэслэл, тулгамдаж байгаа асуудал, бэрхшээлийн цар хүрээг тодорхойлох, холбогдох тоон болон чанарын мэдээлэлд дүн шинжилгээ хийх;

⁴ 17.1.2.асуудлыг шийдвэрлэх арга замыг тодорхойлж, гарах үр дүн, үр нөлөөг эдийн засаг, нийгмийн хөгжлийн загвар, төсөөлөлд үндэслэн бодлогын хувилбарыг боловсруулах;

⁵ 18.2.1.улсын болон орон нутгийн төсөв;

⁶ 18.2.2.гадаадын зээл, тусламж;

Шилүүстэй сумын төсөвт байгууллагуудын 2017 оны үйл ажиллагааны үр дүн

Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг 4 бодлогын хүрээнд 26 зорилт 69 арга хэмжээ хэрэгжүүлэхээр үндсэн чиглэлд тусгасан асуудлуудын хөрөнгийн эх үүсвэрийн тооцооллыг асуудал нэг бүрээр үзэж нэгтгэж дүн шинжилгээ хийлээ.

Санхүүгийн эх үүсвэрийн төсөөллийг авч үзэхэд:

д/д	Санхүүжилтийн эх үүсвэр	Зорилтуудын тоо	Хөрөнгийн эх үүсвэр /сая-р/	Эзлэх хувь
1	Улсын төсвийн хөрөнгө оруулалт		10,9	5,1%
2	Орон нутгийн төсөв		27,4	12,7%
3	Дотоод гадаадын төсөл арга хэмжээ		4,0	1,8%
4	ОНХС		60,3	28,4%
5	ЖДҮДС		10,0	4,6%
6	ХЭДС		5,9	2,7%
7	СХС		80,0	37,2%
9	БХНСАХЗ		2,0	0,9%
11	Бусад эх үүсвэр		14,2	6,6%
	Бүгд		214,7	100%

Нийт санхүүгийн эх үүсвэрийн 37,2%-ийг СХС-ийн эх үүсвэрээс ,УТХО-р 5,1%-ийг дотоод гадаадын төсөл арга хэмжээнээс 1,8%-ийг ОНХС-ийн хөрөнгөөр 28,4%-ийг , бусад эх үүсвэрүүдээс 27,5%-ийг санхүүжүүлэхээр төсөөлөл хийсэн байна.

Дээрхи төсөөллөөс дүгнэлт хийхэд санхүүгийн эх үүсвэрүүдийг бодитой тооцоолоогүй ихэнх дэвшүүлсэн асуудлуудын хөрөнгийн эх үүсвэрүүдийг төсөл хөтөлбөрүүдийн нэрээр ерөнхий тавьж өгсөн байна.

Дэвшүүлсэн асуудлууд нь ерөнхийдөө өмнө жилүүдээс дамжин ирсэн байгууллагууд дээр жил тутамд хэрэгждэг асуудлууд байгаа бөгөөд санхүүгийн эх үүсвэрийн ихэнх төсөөллийг тусгай сангууд, байгууллагын өөрийн хөрөнгөөр хийгдэнэ гэж төсөөлсөн байна.

Сумын засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг ИТХ-ын 2016 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 07 тогтоолоор баталжээ.

2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийг сумын Засаг дарга Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоолоор батлагдсан "Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам"-ын 33-д заасны дагуу иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэхээр хүргүүлжээ.

Үйл ажиллагааны хөтөлбөрийн товъёог

д/д	Бодлогын нэр	Салбарын нэр	Хэрэгжүүлэх арга хэмжээний тоо
-----	--------------	--------------	--------------------------------

Шилүүстэй сумын төсөвт байгууллагуудын 2017 оны үйл ажиллагааны үр дүн

1	Эдийн засгийн хөгжил	Санхүү, эдийн засаг	9
		Хүнс, хөдөө аж ахуй	15
		Аж үйлдвэр, худалдаа үйлчилгээ	4
		Дэд бүтэц	2
		Хот төлөвлөлт, барилга, газар зохион байгуулалт	5
1-р бодлогын арга хэмжээний тоо		33	
2	Байгаль орчин, аялал жуулчлал, ногоон хөгжил	Байгаль орчин	11
		Аялал жуулчлал	2
2-р бодлогын арга хэмжээний тоо		13	
3	Нийгмийн хөгжил	Эрүүл мэнд	17
		Нийтийн биеийн тамир, спорт	7
		Боловсрол	12
		Соёл урлаг	6
		Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжил	2
		Хөдөлмөр, нийгмийн халамж нийгмийн даатгал, Хөдөлмөр эрхлэлт	6
3-р бодлогын арга хэмжээний тоо		55	
4	Засаглал	Төрийн алба	14
		Гадаад харилцаа	2
		Хууль, эрх зүй	13
		Батлан хамгаалах	4
		Онцгой байдал	3
4-р бодлогын арга хэмжээний тоо		36	
Нийт арга хэмжээний тоо		137	

Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг журмын 31.1-31.7-д заасан хавсралт, мэдээллийн хамт Хурлын ажлын албанд хүргүүлэх ёстойч шаардлага хангахгүй баримтууд байна.

Сумын ИТХ-нь төсөл хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээнүүдээс сумын Засаг даргын бүрэн эрхэд нөлөөлөх, ард иргэдийн саналгүй, олон нийтийн эрх ашигт нөлөөлөх асуудлуудад дүн шинжилгээ хийлгүйгээр шууд 100% баталж байгаа нь Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам"-ын 33-34 дэх заалтуудыг зөрчиж байна.

Сумын засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг сумын ИТХ-ын 2016 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 07 тогтоолоор баталжээ.


Шилүүстэй сумын төсөвт байгууллагуудын 2017 оны үйл ажиллагааны үр дүн

Үйл ажиллагааны хөтөлбөрийн бодлого, зорилт, заалтуудыг нягталж үзэхэд сумын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх 2017 оны үндсэн чиглэлтэй уялдаж байгаагаас гадна шалгуур үзүүлэлт, хэрэгжих хугацаа, хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт, хөрөнгийн хэмжээг эх үүсвэрийг хөтөлбөрт тусгаж өгөөгүй үндсэн чиглэлд тусгаж өгсөн байна.

1.3.Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, үндсэн чиглэлийн тайлагналт хуульд заасан хугацаанд хийгдэж байгаа боловч, хяналт-шинжилгээ, үнэлгээний явцын хяналт хангалтгүй байна гэж үзлээ.

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.6⁷, 15 дугаар зүйлийн 15.7⁸, 15.8⁹ дугаар заалтууд, засгийн газрын 2017 оны 89 дүгээр дүгээр тогтоолоор баталсан Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын заалтуудыг хэрэгжүүлэхийн тулд дараахь ажлуудыг хийхээр төлөвлөж сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан байна.

Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээг дараах үе шаттайгаар зохион байгуулна.



Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үр дүнг бүтэн жилээр сумын Иргэдийн төлөөлөгчдийн хуралдаанаар хэлэлцэж байгаа нь Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4¹⁰-д /Тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүр хэлэлцэн дүгнэнэ/гэсэн заалттай нийцэж байна.

⁷ 14.6.Нутгийн захиргааны байгууллага аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилтын хэрэгжилтийн явцад хоёр жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дөрвөн жил тутам хөндлөнгийн үнэлгээ хийлгэх ажлыг зохион байгуулж, тайланг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.

⁸ 15.7.Нутгийн захиргааны байгууллага Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хоёр жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж, 02 дугаар сарын 20-ны дотор Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.

⁹ 15.8.Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хоёр жил тутам, дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд шаардлагатай тохиолдолд хөндлөнгийн үнэлгээ хийлгэх ажлыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурал зохион байгуулна.

¹⁰ 15.4.Тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүр хэлэлцэн дүгнэнэ.

Шилүүстэй сумын төсөвт байгууллагуудын 2017 оны үйл ажиллагааны үр дүн

Харин сумын ИТХ нь Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг зохион байгуулаагүй, ЗДТГ нь бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн явцад хөндлөнгийн үнэлгээ хийх ажлыг жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусгаж хэрэгжүүлэхгүй байгаагаас дүгнэхэд бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгдээгүй байна.

Өөрөөр хэлбэл Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.8¹¹, 20 дугаар зүйлийн 20.1¹² дэх заалтуудыг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Тус сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2017 оны үндсэн чиглэлийн хэрэгжилтийг шалгаж үзэхэд дараах байдалтай дүгнэсэн байна.

Үндсэн чиглэлд 105 асуудал хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 57 асуудал 100%, 32 асуудал 70%, 1 асуудал 90%-тай хэрэгжиж, 2 асуудал хэрэгжээгүй 30%-тай, 13 асуудалд үнэлгээ өгөөгүй байна.

Үндсэн чиглэлийн асуудлуудыг хэт жижигрүүлж, зарим асуудлыг нэгтгээгүй, дүгнэлт өгөх боломж муутай асуудлуудыг тусгасан гэж үзэх үндэстэй байна

Үндсэн чиглэлийн асуудлуудыг хянаж үзэхэд хөтөлбөрүүд хэрэгжүүлэх, сургалт, зөвөлгөөнд оролцох, тэмцээний ажлууд нийлээд хувийг эзэлсэн хөрөнгө оруулалтын шинж чанартай ажлууд дутмаг тусгагдсан байна.

Нийт дундаж оноогоор 83,7%-тай дүгнэсэн биелэлт гаргасан байна. Үндсэн чиглэлийн хэрэгжилтийг сумын ЗДТГ-ын ажилтнууд дүгнэсэн бөгөөд Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, дотоод аудитын хэлтэс нь Засгийн газрын 89 дүгээр тогтоолын дагуу үнэлгээ хийгээгүй байна.

Аудитын явцад зарим нэг асуудлуудын хэрэгжилтийг үзэхэд дараахь асуудлууд хангалттай хэрэгжсэн байна. Үүнд:

- ❖ БОХ-ын байцаагч болон байгал хамгаалах нөхөрлөлийн гишүүнийг 2 ш 3500.0 мянган төгрөгийн мотоциклоор хангасан
- ❖ 500 ш чацарганы мод суулгаж үр дүнгээ өгч эхэлсэн
- ❖ Малчдын өвөлжөө, хаваржааны хашааг засварлахад 12700.0 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлсэн



¹¹ 15.8.Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хоёр жил тутам, дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд шаардлагатай тохиолдолд хөндлөнгийн үнэлгээ хийлгэх ажлыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурал зохион байгуулна.

¹² 20.1.Хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэгч байгууллага нь бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн явцад хөндлөнгийн үнэлгээ хийх ажлыг жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусгаж, шаардагдах зардлыг улсын болон орон нутгийн төсвийн багцад тусгаж, батлуулсан байна.

Шилүүстэй сумын төсөвт байгууллагуудын 2017 оны үйл ажиллагааны үр дүн

- ❖ Сумын малын тэжээл тариалалтыг нэмэгдүүлж, сумын аюулгүй нөөцийг иргэд, байгууллагын дэмжлэгээр өвс тэжээл бүрдүүлсэн
- ❖ Сайн хашаа” аян зохион байгуулж 43 хашааны дааманг шинээр сольж сумын өнгө үзэмжийг дээшлүүлсэн
- ❖ Утасгүй интернэт төхөөрөмжид нийт 4 албан газар, 120 өрх хамрагдан ашиглалтанд бүрэн орсон үр дүнгээ өгч зарим ажлууд хэрэгжих шатандаа байна



Харин хэрэгжээгүй буюу удааширалттай дараах ажлуудад анхаарч ажиллах шаардлагатай байна. Үүнд:

- ❖ ЕБС, соёлын төвийг цахилгаан монтаж шинэчлэх
- ❖ Урлагын хувцасны нөөц бүрдүүлэх
- ❖ Оны шилдэг хүүхэд шалгаруулах, ёслолын үйл ажиллагаанд төлөөлөгч оролцуулах
- ❖ Оны тэргүүний албан Сургуулийн дотуур байрыг засварлах зэрэг хөрөнгө эх үүсвэрийн дутагдалтай ажлуудад дүнэлт хийж ажиллах шаардлагатай гэж үзлээ

Гүйцэтгэлийн аудитаар тус суманд 5 хоног ажилласан бөгөөд ОНХС, СХС, үндсэн чиглэлийн хэрэгжилтээр зарим хийгдсэн ажлуудыг биечлэн үзлээ. Ажиглалтаар тус суманд нийтийн эзэмшлийн болон цаашид ЗДТГ-т үр өгөөжөө өгч болох дараахь барилга объектууд байна.

- ❖ Сумын халуун усны барилга
- ❖ Сумын ЗДТГ-ын буудлын барилга

Дээрх барилгуудын халаалтын асуудлуудыг тодорхой үе шаттайгаар санхүүжүүлэн ажилд оруулбал сумын иргэдийн ая тухтай орчин бүрдэх мөн ажлын байр бий болох боломжууд байна гэж үзлээ.

Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг олон нийтэд мэдээлэх үйл ажиллагаа хуулийн дагуу явагдаагүй, аймгаас арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах ажлыг зохион байгуулсан хэдий ч үр дүнгээ өгөөгүй байна .

Батлуулсан, үйл ажиллагааны хөтөлбөрөө сумдын багийн ИНХ-аар олон нийтэд мэдээлсэн гэх бөгөөд зохион байгуулсан ажил баримтаар нотлогдохгүй байна.

Шилүүстэй сумын төсөвт байгууллагуудын 2017 оны үйл ажиллагааны үр дүн

Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, үндсэн чиглэлийн нийт ард иргэдэд сурталчилан танилцуулах ажиллагаа хангалтгүй байгаа нь Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1¹³, 22.2¹⁴ дэх заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Аудитын явцад сумдад ажиллан хөгжлийн бодлого төлөвлөлтийн хуулийн талаар ажлын хэсгийн ахлан хийж байгаа албан хаагч мэргэжилтнүүдээс аман асуулга хийж тодруулахад хуулиа сайн судлаагүй “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”-ын талаарх мэдлэг мэдээлэл хангалтгүй байлаа.

Аймгийн ЗДТГазрын Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсээс хөтөлбөрийг боловсруулах ажлын хэсгийн ахлагч буюу холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэх албан хаагчдад хуулийн талаар сургалт сурталчилгаа хийгээгүй байна. Харин Хяналт- шинжилгээ үнэлгээний хэлтсээс арга зүйн зөвлөгөө өгөх, чадавхыг бэхжүүлэх ажлыг зохион байгуулсан байна.

Бүлэг 2. Сумын төсөвт байгууллагууд төсвийн санхүүжитийг бүрэн авч, холбогдох зардлуудад зарцуулсан байна.

Бүлэг-2.1 Орон нутгийн татварын орлогын давсан хэсгийг ирээдүйд ард иргэдэд үр өгөөжөө өгөх үр дүнтэй арга хэмжээнд зарцуулах нь зүйтэй гэж үзлээ.

Орон нутгийн татварын орлогоор 24800.0 мянган төгрөгийг төвлөрүүлэхээс 55370.9 мянган төгрөгийг төвлөрүүлж батлагдсан төлөвлөгөөг 123.0%-иар буюу 30570.9 мянган төгрөгөөр давуулан биелүүлжээ.

Орлогын төлөвлөгөөний биелэлтийг нэр төрлөөр нь авч үзвэл: Суутгагчийн хувь хүнд олгосон татвар 15751.4 мянган төгрөгөөр, ус, рашааны нөөц ашигласны төлбөр 35.8 мянган төгрөгөөр давж биелэн үйл ажиллагааны орлогын албан татвар 8124.0 мянган төгрөгөөр, улсын тэмдэгтийн хураамж 2835.1 мянган төгрөгөөр, галт зэвсгийн татвар 1720.0 мянган төгрөгөөр, түгээмэл тархацтай ашигт малтмалын төлбөр 130.0 мянган төгрөгөөр, нэр заагдаагүй орлогууд 1150.0 мянган төгрөгөөр тус тасарсан дүнтэй гарчээ.

¹³ 22.1.Батлагдсан хөгжлийн бодлогын баримт бичгийг олон нийтэд мэдээлэх, хэвлэх, сурталчлах ажлыг тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон нутгийн захиргааны байгууллага хариуцан зохион байгуулна.

¹⁴22.2.Төрийн захиргааны төв байгууллага тухайн салбарын бодлогын залгамж чанарыг хадгалах зорилгоор өмнө хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ, цаашид авч хэрэгжүүлэх бодлого, арга хэмжээг нэгтгэсэн эмхэтгэлийг жил бүр олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлж, хэвлэн нийтэлнэ.

Шилүүстэй сумын төсөвт байгууллагуудын 2017 оны үйл ажиллагааны үр дүн

Давсан орлогын талаар

- Харин тус суманд орлого давж биелэх шалтгаан нь төлөвлөгөөгүйгээр ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогоор 29001.8 мянган төгрөг төвлөрсөн .
- Цалин хөлс болон түүнтэй адилтгах орлого,суутгаагчийн хувь хүнд олгосон орлогын татвар 15751.4 мянган төгрөгөөр давж биелэсэн нь УИХ-ын 2017.11.09-ны 67 дугаар тогтоолоор олгосон төрийн албан хаагчдад олгосон урамшуулал 3464.0 мянган төгрөг, ноосны урамшуулалын 4705.1 мянган төгрөг нөгөө талаас үйл ажиллагааны орлогын албан татвар гүйгэдэн тайлагнагдсантай холбоотойгоор
- Иргэдийн хадгаламжийн хүүгийн орлогоор 2856.2 мянган төгрөг орсон нь 2017.05.01-ээс хууль хэрэгжиж эхэлсэнтэй /ХХОАТ-ын 4 дүгээр зүйлийн 4.1.1-р заалт/ холбоотой байна.

Татварын орлогын тасарсан шалтгаан

- Нэр заагдаагүй бусад орлого 100% тасарсан нь төлөвлөгөө өндөр батлагдсан мөн татварын байцаагч нь улсын байцаагчийн эрхгүй тул акт ногдуулах боломжгүй байдаг нь
- үйл ажиллагааны орлогын албан татвар, улсын тэмдэгтийн хураамжийн орлого, галт зэвсгийн албан татварууд тасарч байгаа нь төлөвлөгөө бодит байдалтай уялдаагүй хэт өндөр төлөвлөгдсөнтэй холбоотой байна.

Сумын аймагт төвлөрүүлдэг орлогууд нийт дүнгээрээ 1219.9 мянган төгрөг буюу 2%-иар 2 нэр төрөл дээр тасарсан байна. Газрын төлбөр, АТБӨЯХАТ-ын орлогуудын төлөвлөгөө бодит байдлаас өндөр төлөвлөгдсөнтэй холбоотойгоор 1517.4-2252.0 мянган төгрөгөөр тасарсан байна.

Орон нутгийн татварын орлого нэмэгдэх нөөц боломж байгаа талаар сумын удирдлагууд болон татварын байцаагч бусад холбогдох ажилтнуудтай ярилцлага хийхэд нөөц боломж муу байгаа талаар ярилаа.

Тухайн суманд ой мод байдаггүй нөгөө талаас байгалийн гаралтай жимс жимсгэнэ ургадаггүйгээс гадна сүүлийн жилүүдэд томоохон хэмжээний хөрөнгө оруулалтын ажлууд хийгдээгүй байна.

Тус сумын ан амьтны нөөц ашигласаны төлбөрийн орлого тасарвал орон нутгийн татварын орлого нийт дүнгээрээ тасрах магадлалтай байгаа тул орлого нэмэгдүүлэх бусад боломж байгааг судалж үзэх нь зүйтэй гэж үзлээ.

Орон нутгийн татварын орлогыг нэмэгдүүлэх зорилгоор өөрийн нутагт байрших тээврийн хэрэгслүүдийн харьяаллыг өөрчлүүлэх, устаж үгүй болсон болон худалдан

Шилүүстэй сумын төсөвт байгууллагуудын 2017 оны үйл ажиллагааны үр дүн

борлогдсон хэрэгслүүдийг тодорхой болгож Үндэсний татварын газрын бүртгэлээс хасуулах, төлөвлөгөөг бодитой төлөвлөхөд анхаарч ажиллах нь зүйтэй гэж үзлээ.

Мөн түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийн орлогыг нэмэгдүүлэх, бусад татварын орлогуудын төлөвлөгөөг бүх нэр төрөл дээр жигд биелүүлэх ажилд сумын удирдлагууд, татварын байцаагч нар тодорхой ажил зохион байгуулж үр дүнг тооцох шаардлагатай байна гэж үзлээ.

2018 оны татварын орлогын төлөвлөгөөг 2017 оны гүйцэтгэлтэй харьцуулан үзэхэд зарим төрлийн татвар нэр төрөл дээр буурч төлөвлөгдсөн ч нийт дүнгээрээ сумын татварын орлого 30840.3 мянган төгрөгөөр, улсын төсвийн орлого 339.4 мянган төгрөгөөр тус тус буурч төлөвлөгдөн харин аймагт төвлөрүүлэх татварын орлого 1589.9 мянган төгрөгөөр нэмэгдэн батлагдаж төлөвлөгдсөн байна.

2016 оны орон нутгийн татварын давсан орлого, үлдэгдэл санхүүжилтийн 50404.9 мянган төгрөгийг баталсан хуваарь, тогтоолын дагуу бүрэн зарцуулж, татварын буцаан олголтоор 13427.5 мянган төгрөгийг олгосон байна.

Орон нутгийн татварын давсан орлогын зарцуулалтыг нягталж үзэхэд дараахь зарцуулалтуудыг зөрчилтэй гэж үзлээ. Үүнд:

- ❖ Малчдын өвөлжөө, хаваржааны хашааг засварлахад 12700.0 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлсэн
- ❖ “Сайн хашаа” аян зохион байгуулж 43 хашааны дааманг шинээр солисон

Дээрхи 2 ажил нь сумын засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг нийгмийг хөгжүүлэх 2017 оны үндсэн чиглэлд тусгагдан, сумын ИТХ-ын тогтоолоор батлагдсан арга хэмжээ боловч зориулалт ангилалтын хувьд ОНХС-ийн зарцуулах журам зөрчсөн, нөгөө талаас төсвийн хөрөнгөөр иргэдийн хувийн эзэмшлийн хашаа, өвөлжөөг засварласан арга хэмжээ болсон тул цаашид дахин энэ төрлийн арга хэмжээнд төсвийн хөрөнгө зарцуулахгүй байх талаар аудитаар сумын холбогдох удирдагуудад зөвлөмж өглөө.

Улсын төсөвт төвлөрдөг татваруудын талаар

Тус суманд бүртгэлтэй 23 аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаа явуулж байгаагаас 10 аж ахуйн нэгжүүдээс татвар хурааж, Агаарын бохирдлын хураамжийг нийт бүртгэлтэй 210 автотээврийн хэрэгсэлд ногдуулж байгаа бөгөөд НӨТ-ийн албан татвар төлдөг байгууллага байхгүй байхад 500.0 мянган төгрөгийн НӨТ-ийн албан татвар ногдуулсан нь бодит нөхцөл байдалтай уялдахгүй байгаа нь аудитын явцад ажиглагдлаа.

Мөн тус суманд байгаа 164 автотээврийн хэрэгслээс 123 хэрэгсэл ЗАН дугаартай 41 хэрэгсэл УБ болон бусад аймаг хотуудын дугаартай тул татварыг ногдуулан харьяалагдах татварын дансанд барагдуулж өгдөг байна. Энэ байдлаас дүгнэхэд орон нутгийн татварын орлогыг нэмэгдүүлэх зорилгоор өөрийн нутагт байрших тээврийн хэрэгслүүдийн харьяаллыг өөрчлүүлэх, устаж үгүй болсон болон худалдан борлогдсон

Шилүүстэй сумын төсөвт байгууллагуудын 2017 оны үйл ажиллагааны үр дүн

хэрэгслүүдийг тодорхой болгож татварын газрын бүртгэлээс хасуулах, төлөвлөгөөг бодитой төлөвлөхөд анхаарч ажиллах нь зүйтэй гэж үзлээ.

Цаашид орлогын төлөвлөгөөг биелүүлэх боломжгүй нэр төрлүүдийн талаар холбогдох газарт уламжилж төлөвлөгөөг бодит байдалтай уялдуулан төлөвлөх нь зүйтэй гэж үзлээ.

2017 оны галт зэвсгийн албан татварын ногдуулалт 6*3000-210.0 мянган төгрөг, өвөлжөө, хаваржаа зээмшиж байгаа иргэдийн газрын төлбөрийн 26*4000-104.0 мянган төгрөг, АТӨЯХАТ-ын 130.8 мянган төгрөгийн нийт 444.8 мянган төгрөгийн хураан барагдуулаагүй татварын үлдэгдэл байгааг 2018 онд бүрэн барагдуулж оруулах нь зүйтэй гэж үзэн үр өгөөж тооцлоо.

2.2 ОНХС-ийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Шилүүстэй сум нь 2017 онд ОНХС-ийн хөрөнгөөр 5 төсөл арга хэмжээг 11,38 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнд:

/сая,төг/

д/д	Төсөл арга хэмжээний нэр	дүн
1	Баяр наадам	5,0
2	Гамшигаас хамгаалах сан	1,0
3	Малчдын өвөлжөө засах	4,28
4	Гудамжны гэрэлтүүлэг засвар	0,5
5	Бог малын үйлдвэр угсаа сайжруулах	0,6
дүн		11,38

ОНХС-ийн төлөвлөлтийг судлан үзэхэд малчдын өвөлжөө засах ажил нь Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан ОНХС-ийн зааварт тусгагдсан хэрэгжүүлэх боломжтой чиг үүрэгтэй нийцэхгүй байна гэж үзлээ.

Мөн орон нутгийн татварын давсан хэсгийг ОНХС-д төвлөрүүлэн дараах ажил гүйцэтгэхээр төлөвлөсөн байна.

д/д	Төсөл арга хэмжээний нэр	дүн
1	Сайн хашаа	12,75
2	Хүндэтгэлийн өргөө	1,0
дүн		13,75

Энэхүү ажил хийгдсэн бөгөөд уг асуудлыг татварын орлогын хэсэгт дэлгэрэнгүй тусгасан болно.

Шилүүстэй сумын төсөвт байгууллагуудын 2017 оны үйл ажиллагааны үр дүн

ОНХС нь 2017 онд аймгийн ОНХС-аас 9,45 сая төгрөг, нэмэлт санхүүжилтээр 3,0 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 13,75 сая төгрөг, нийт 26,2 сая төгрөгийн санхүүгийн эх үүсвэртэй ажилласан байна.

ОНХС нь 2017 онд 21,3 сая төгрөгийн зардал гарган, 4,9 сая төгрөгийн үлдэгдэлтэй ажилласан байна. Зарцуулалтыг судлан үзэхэд:

- Төлөвлөгөөнд тусгагдсан 5 төсөл арга хэмжээнээс 2 ажилд 6,6 сая төгрөг / баяр наадмын зардалд 5,0 сая, малчдын өвөлжөө засах ажилд 1,6 сая төгрөг/
- Нэмэлт санхүүжилтээр хийгдсэн эрүүл мэндийн төвд өвчтөний ор, шүүгээ нийлүүлэх ажилд 3,0 сая төгрөг,
- Орон нутгийн давсан орлогоос хийгдэх 2 төсөл арга хэмжээнд 11,7 сая төгрөг / сайн хашаа 11,1 сая, хүндэтгэлийн өргөө 0,6 сая төгрөг/ тус тус зарцуулжээ.

Аудитаар ОНХС-ийн зарцуулалттай холбоотой алдаа зөрчил илрээгүй болно.

2.3.Төрийн аудитын байгууллагын өгсөн албан шаардлагын биелэлтийг хангуулан ажиллаж байна.

СХС 2017 онд хүүгийн орлогоор 3,8 сая төгрөг, зээлийн эргэн төлөлтөөс 56,5 сая төгрөгийн нийт 60,3 сая төгрөгийн орлого төвлөрүүлэн ажилласан байна.

2017 онд иргэдээс авах авлагын үлдэгдэл 214,1 сая төгрөг, үүнээс 38 иргэнтэй холбоотой хугацаа хэтэрсэн 78,4 сая төгрөгийн авлага байсанд санхүүгийн аудитаар албан шаардлага хүргүүлэн ажилласан байна.

Аудитаар албан шаардлагын биелэлтийг үзэхэд хугацаа хэтэрсэн авлагаас 31,1 сая төгрөг төвлөрүүлсэн нь 39,6%- тай байна.

Хугацаа хэтэрсэн зээлтэй иргэдийг судлан үзэхэд:

- Нас барсан 3 иргэнтэй холбоотой 8,9 сая төгрөг
- Хот, аймаг шилжсэн 4 иргэнтэй холбоотой 3,6 сая төгрөгийн зээл байна.

Дээрх байдлаас дүгнэхэд иргэдийг зээлээ төлсөний дараа шилжилт хөдөлгөөнийг хийдэг байх нь зүйтэй гэж үзлээ.

2017 онд зээлийн эргэн төлөлтийн орлогоос 32 иргэнд 66,9 сая төгрөгийн зээлийг олгон, хэрэгжилтэнд нь хяналт тавин ажиллаж байна.

Аудитаар СХС-ийн үйл ажиллагаатай холбоотой алдаа зөрчил илрээгүй болно.

Шилүүстэй сумын төсөвт байгууллагуудын 2017 оны үйл ажиллагааны үр дүн

ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН:

Тус байгууллага нь үйл ажиллагааны төлөвлөгөөндөө хуулиар хүлээсэн үүргээ бүрэн тусгаж, зорилго зорилтоо үнэн зөв тодорхойлжээ.

Тайлант хугацаанд сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал “Тасралтгүй үйл ажиллагаатай, хууль эрх зүйн орчинг бүрдүүлэн сумын ард иргэдийн аж амьдралыг дээшлүүлж ая тухтай ажиллаж амьдрах нөхцөл бүрдүүлэх” зорилт дэвшүүлэн ажиллажээ.

Эдийн засаг нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд 4 төрлийн 46 арга хэмжээ хэрэгжүүлэхээс 45 төрлийн арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж 1 арга хэмжээ хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийг сар бүрийн эхний долоо хоногийн Лхагва сүүлийн долоо хоногийн Даваа гаригт хуралдуулж хэвших гэсэн 1 арга хэмжээ хэрэгжээгүй бусад арга хэмжээ бүрэн хэрэгжиж төлөвлөгөөний биелэлтийг 97 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Дээрхи байдлаас дүгнэхэд Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал төлөвлөсөн ажлуудаа хангалттай хийсэн гэж үзэх үндэстэй байна.

Улсын төсвөөс авсан санхүүжилтийг зориулалтын дагуу бүрэн зарцуулсан байна.

2017 онд урсгал үйл ажиллагааны зардлын санхүүжилт 38.8 сая төгрөг, төрийн албан хаагчдад олгох нэг удаагийн тэтгэмж 0.6 сая төгрөг, нийт 39,4 сая төгрөгийн санхүүжилттэй ажилласан байна.

Төсвийн зарлагыг 2017 онд 39,4 сая төгрөгөөр баталсан бөгөөд зарим зардлын хэтрэлт, хэмнэлтийг хүснэгтээр харуулбал: /мянган .төгрөгөөр/

Зардлын зүйлийг эдийн засгийн ангилалаар нь авч үзэхэд:

д/д	Зардлын зүйл	Төлөв лөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт	Хэмнэлт
1	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	32865,9	31377,0	0	1488,8
2	НДШ	3615,2	3444,6	0	170,5
6	Бичиг хэрэг	85,0	285,7	-200,7	0

Шилүүстэй сумын төсөвт байгууллагуудын 2017 оны үйл ажиллагааны үр дүн

7	Тээвэр шатахуун	328,2	1374,0	-1045,8	0
8	Шуудан холбоо	138,1	71,4		66,6
14	Томилолт	298,8	448,8	-150,0	0
15	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж	284,3	1854,0	-1569,7	0
17	Нэг удаагийн тэтгэмж	600,0	600,0	0	0

Тус Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь 2017 онд нийт 39.4 сая төгрөгийн зардалтай үйл ажиллагаа явуулсан байна.

Хэтэрсэн болон хэмнэгдсэн зардлууд нь дараах шалтгаантай байна.

- Цалин хөлс болон нэмэгдэл урамшилын зардлыг 1488,8 мянган төгрөгөөр хэмнэсэн нь цалингийн хэмнэлт гарсан.
- НДШ-ийн зардлыг 170,5 мянган төгрөгөөр хэмнэсэн шалтгаан нь цалингийн сан хэмнэсэнтэй холбоотойгоор.
- Тээвэр шатахууны зардал 1045,8 мянган төгрөгөөр, Бичиг хэргийн зардал 200,0 мянган төгрөгөөр, Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал 1569,7 мянган төгрөгөөр тус тус хэтэрсэн нь татварын давсан орлогоос 2500,0 мянган төгрөгийн санхүүжилт авсантай холбоотой байна.

Аудитаар төсвийн зарцуулалттай холбоотой дараах зөрчил илрүүлээ.

- Автомашины шатахуун зарцуулалтын хэтрэлт хэмнэлтийг тооцдоггүй, шатахуун зарцуулалтад бүртгэлээр тавих хяналт байхгүй, Дуудсан бичиггүйгээр томилолтын зардал гаргасан, Баримтын бүрдүүлэлт дутуу 659,4 мянган төгрөгийг олгосон зөрчил илэрлээ.

Тус Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь батлагдсан орон тоогоор ажилласан байна.

Тус Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь 2017 онд удирдах 1, гүйцэтгэх 1 нийт 2 орон тоотой үйл ажиллагаа явуулсан байна.

Боловсон хүчний цалин тогтоолтыг судлан үзэхэд алдаа зөрчил илрээгүй бөгөөд албан хаагчдын цалин нь үндсэн цалин, зэргийн нэмэгдэл, онцгой нэмэгдэл, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, ЭБАТ-ны ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдлүүдээс бүрдсэн байна.

2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар 0.08 сая төгрөгийн бусад зардлын тооцооны авлагатай гарсан байна.

Шилүүстэй сумын төсөвт байгууллагуудын 2017 оны үйл ажиллагааны үр дүн

Аудитаар илрүүлсэн иргэдийн хурлын төлөөлөгч нарт хуралд оролцох шатахууны үнэ олгосон, анхан шатны бүрдэл дутуу ажил гүйлгээ данс бүртгэлд тусгасан зэрэг зөрчил нь аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны зөрчилтэй давхардсан болно.

Бараа материалыг няравын тайлантай тулган үзэхэд худалдан авсан материалыг бүрэн бүртгэсэн, бараа материалын тайланд алдаа зөрчил илрээгүй болно.

Аудитын явцад хөрөнгийн хэсэгчилсэн тооллого хийхэд зөрчил дутагдал илэрээгүй бөгөөд хадгалалт хамгаалалт сайн бүрэн ашиглагдаж байна.

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН:

ЗДТГ-ын санхүүгийн баримтын эмх цэгц сайн, төсвийн зарцуулалтанд тавих төрийн сангийн хяналт сайжирсан төсвийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

ЗДТГ төсвөөс авах 233914.3 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн, орон нутгийн татварын орлогоор 32165.5 мянган төгрөг, НД-ийн сангаас листний 2293.4 мянган төгрөгийн орлогуудыг тус тус төвлөрүүлж нийт 268373.3 мянган төгрөгийн орлоготой үйл ажиллагаа явуулжээ.

ЗДТГ- төвлөрсөн орлогыг бүрэн зарцуулсан бөгөөд төсвийг 16270.6 мянган төгрөгийн давсан орлогоор хэтрүүлэн зарцуулсан байна.

Төсвийн зарцуулалтыг зардлын нэр төрлөөр авч үзэхэд цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 8854.5 мянган төгрөгөөр, НДШ-ийн зардал 1505.7 мянган төгрөгөөр хэмнэгдэж, хангамж бараа материалын зардлыг 6521.7 мянган төгрөгөөр, албан томилолтын зардлыг 1011.6 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 10550.0 мянган төгрөгөөр тус тус хэтрүүлсэн зарцуулсан байна.

Давсан орлого, цалингийн сангийн нэмнэлтээс шалтгаалан зардал хэтрэсэн байна.

- Төсвийн зарцуулалтыг хянаж үзэхэд:
- Төсвийг зориулалтын дагуу бүрэн зарцуулсан бөгөөд өмнөх оны давсан орлогоос бэлтгэсэн “Хүйн холбоо буюу цагийн эрхээр харьд одсон монгол эрийн цадиг хуучин хэлхээ оршивой” номыг /300 ш *5000/- 1500.0 мянган төгрөгөөр худалдан авч 24 ш-ийг иргэдэд өгч, 49 ш-ийг сумын төсөвт байгууллагуудад тараан олгож, 87-ш-ийг зарж борлуулан 181.2 мянган төгрөгийг дансанд төвлөрүүлэн, 137.3 мянган төгрөгөөр архивын ширээ авч, 116.5 мянган төгрөгөөр засвар хийж, 140 ш номын үлдэгдэл байна.

Аудитаас дээрх номын үлдэгдлийн зарж борлуулах, төсөвт байгууллагуудаас авах номын үнийг гаргуулан байгууллагын дансанд төвлөрүүлэх зөвлөмж өглөө

Шилүүстэй сумын төсөвт байгууллагуудын 2017 оны үйл ажиллагааны үр дүн

- Тээвэр шатахууны зардал 4953.5 мянган төгрөгөөр хэтэрсэн байгаад дүгнэлт хийж Замын хуудсанд үйлчилгээний машины спидометрийн заалтыг бүрэн бичүүлж ажил үйлчилгээнд унаж явсан албан тушаалтаны хүлээн зөвшөөрсөн гарын үсгийг зуруулан тээвэр шатахууны зардлын гүйцэтгэлийг хянан сар бүр жолоочийн тооцоог бодож МУ-ын Засгийн газрын 2007 оны 349-р тогтоолыг хэрэгжүүлэх шатахууны хэтрэлт хэмнэлтийн тооцоог хийж байх

Төсвийн зарцуулалттай өөр зөрчил илрээгүй бөгөөд аймгийн ЗДТГ-ын дэргэдэх санхүүгийн дотоод аудитын албанаас 2017-2018 оны эхний улирлыг хамруулан 3 удаа хяналт хийсэн, 2018 оны эхний улирлын хяналтаар нийт төсөвт газрууд 11832.9 мянган төгрөгийн нөхөн төлбөр тогтоосон бөгөөд ЗДТГ-т 1317.0 мянган нөхөн төлбөр ногдуулсан нь *УИХ-ын 2017.11.09-ны 67 дугаар тогтоолоор олгосон төрийн албан хаагчдад олгосон урамшуулалттай холбоотой байна.*

ЗДТГ-ын санхүүгийн баримтын эмх цэгц сайн, төсвийн зарцуулалтанд тавих төрийн сангийн хяналт сайжирсан 2017 оны санхүүгийн тайлан баталгаажуулалтаар “Зөрчилгүй” дүгнэлт авсан, төсвийг зориулалтын дагуу зарцуулсан гэж дүгнэж байна.

Сумын ЗДТГ-ын бүтэц орон тоо Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 425 дугаар тогтоолыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тус сумын орон нутгийн захиргааны байгууллагуудын орон тоо бүтцийг шалган үзэхэд ЗДТГ 2017 онд удирдах 3, гүйцэтгэх 10, гэрээт ажилчин 4 үйлчилгээний ажилтан 2, багийн засаг дарга 4 нийт 23 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байна.

2017 онд цалин болон нэмэгдэл урамшууллын зардалд 185569.4 мянган төгрөг батлагдсан бөгөөд гүйцэтгэлээр 176714.8 мянган төгрөг зарцуулж 8854.5 мянган төгрөгийн хэмнэлттэй зарцуулсан байна. Цалингийн сан хэмнэсэн нь төлөвлөлттэй холбоотой бөгөөд 2018 оны батлагдсан төсөвт бодит байдалтай уялдан төлөвлөгдсөн байна.

Аудитын явцад орон тоо цалин тогтоолт, олголтыг тулган шалгасан бөгөөд зөрчил илрээгүй болно.

Хөрөнгийн хадгалалт, эмх цэгц сайн зориулалтын дагуу ашиглаж байна

Аудитын явцад хөрөнгийн хэсэгчилсэн тооллого хийхэд зөрчил илрээгүй.

Шилүүстэй сумын төсөвт байгууллагуудын 2017 оны үйл ажиллагааны үр дүн

2017 оны жилийн эцэст хөрөнгийн тооллогыг нүд үзэн тоолж бүртгэлийн акт үйдсэн бөгөөд дээрх зөрчлүүдээс өөр зөрчил илрээгүй байгууллагын санхүүгийн баримтын эмх цэгц сайн, бүртгэл хөтлөлтийг шаардлагын хэмжээнд хүргэсэн, төсвийн зарцуулалтанд тавих төрийн сангийн хяналт сайн байна.

ЗДТГ-т гүйцэтгэлийн аудитаар 1500.0 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Тус суманд аудитын баг 5 хоног ажилласан бөгөөд газар дээр нь холбогдох иргэдтэй уулзаж зөвлөгөө, зөвлөмж өгч ажилласан бөгөөд аудитын явцын ажиглалтаар тус сумын санхүүгийн ажилтнууд болон бусад төсөвт газруудын дарга, захирал, эрхлэгч, бүртгэлийн ажилтнуудын хоорондын ажлын уялдаа шаардлагын хэмжээнд хүрээгүй нь аудитаар болон бусад хяналт, шалгалтын байгууллагуудаар их хэмжээний зөрчил илрэх, төлбөрийн акт тогтоогдох эх үүсвэрийг бүрдүүлж байгаа нь ажиглагдлаа. Цаашид ажлын уялдааг сайжруулан хамтарч ажиллах шаардлагатай гэж үзлээ.

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН:

Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт хангалттай байна.

Тус сургууль нь 2017 онд 385 суралцагч, 53 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж, засаг даргатай 16 чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэхээр гэрээ байгуулан ажиллаж 90-100 хувийн гүйцэтгэлтэй 14, 70-80 хувийн гүйцэтгэлтэй 1, 70-с доош хувийн гүйцэтгэлтэй 1 арга хэмжээ байна.

Дээрхи байдлаас дүгнэхэд сургуулийн чиг үүргийн биелэлт 87,5 хувьтай байна гэж үзлээ.

Санхүүгийн эх үүсвэрийг данс бүртгэлд бүрэн тусгасан байна.

2017 онд урсгал үйл ажиллагааны зардлын санхүүжилтэнд 572,4 сая төгрөг, төрийн албан хаагчдад олгох нэг удаагийн тэтгэмж 15,9 сая төгрөг, нийт 588,3 сая төгрөгийн санхүүжилттэй ажилласан байна.

Мөн нэмэлт санхүүжилтийн дансаар сургуулийн гадна сургалтын туршилтын талбай байгуулсаны үлдэгдэл санхүүжилт 1,2 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн төвийн барилгын ажлын засварын 7,7 сая төгрөг, тус төвийн дотор тохижилтын тоног төхөөрөмж худалдан авах 9,9 сая төгрөгийн, нийт 18,8 сая төгрөг орж ирсэнийг данс бүртгэлд тусган ажилласан байна.

Шилүүстэй сумын төсөвт байгууллагуудын 2017 оны үйл ажиллагааны үр дүн

Төсвийн зарлагыг 2017 онд 576,1 сая төгрөгөөр баталсан бөгөөд тодотгол хийж 3,7 сая төгрөгөөр бууруулан баталж, зарим зардлын хооронд зохицуулалт хийсэн байна. Тухайлбал:

д/д	Зардлын ангилал	Анх батлагдсан	Тодотгосон	Зөрүү
1	Үндсэн цалин	383,8	387,4	3,6
2	Ажил олгогчоос төлөх НДШ	42,2	42,6	0,4
3	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,4	40,6	9,2
4	Хангамж, бараа материалын зардал	3,1	7,1	4
5	Нармотивт зардал	54,5	35,4	-19,1
6	Эд хогшил худалдан авах	1,1	1,1	0
7	Томилолт	0,2	0,9	0,5
8	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	1,3	1,8	0,5
9	Бараа үйлчилгээний бусад зардал	2,5	1,5	-1,0
10	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласаны тэтгэмж	40,9	41,6	0,7
11	Үдийн цай	15,1	12,4	-2,7
	ДҮН	576,1	572,4	-3,7

Хүснэгтээс харахад төлөвлөлтийг бодитой хийхгүй байгаа нь харагдаж байна. Ялангуяа цалин хөлс болон түүнтэй адилтгах зардал, тогтмол зардал, хоолны зардал зэргийн төлөвлөлтийг бодитой хийх шаардлагатай байна.

Төсвийг зориулалтын бус үрэлгэн зарцуулсан байна.

ЕБС нь 2017 онд нийт 588.3 сая төгрөгийн зардалтай үйл ажиллагаа явуулсан байна.

Зардлыг бүлгээр нь судлан үзэхэд цалин хөлс болон түүнтэй адилтгах орлого, нийгмийн даатгалын шимтгэл 72.6 хувь, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 6.7 хувь, нормативт зардал 6.3 хувь, тэтгэмжийн зардал 11.5 хувь, байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахтай холбоотой бусад зардал 2.9 хувь байна.

Төсөвт тодотгол хийж, зарим зардалд зохицуулалт хийсэн хэдий ч бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан зөрчил байна. Тухайлбал:

- Цалин хөлс, ажил олгогчоос төлөх НДШ, тогтмол зардал, хангамж бараа материалын зардал зэргээс хэмнэгдсэн хэсгийг урсгал засвар, бараа үйлчилгээний бусад зардлуудад,

Шилүүстэй сумын төсөвт байгууллагуудын 2017 оны үйл ажиллагааны үр дүн

➤ Хоолны зардлаас үдийн цайны зардалд зарцуулсан зэрэг байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5."батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Аудитаар төсвийн зарцуулалттай холбоотой нутгийн зөвлөлийн уулзалтанд бэлэг дурсгалын зүйл авч явсан, томилолт олгосон, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн төвд нийлүүлэх тоног төхөөрөмж дутуу нийлүүлэгдсэн, үдийн цай болон дотуур байрны хүүхдийн хоолонд худалдан авсан хүнсний материалыг няравын тайланд тусгаагүй зэрэгтэй холбоотой 8,5 сая төгрөгийн зөрчил илрүүлж, дутуу нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжийг бүрэн нийлүүлэх талаар албан шаардлага хүргүүлэн ажиллаа.

Мөн аудитаар илрүүлсэн хууль журам зөрчиж үр дүнгийн урамшуулал авсан, хувь хүнээс орлогын албан татвар суутган тооцоогүй, анхан шатны баримтгүй ажил гүйлгээ данс бүртгэлд тусгасан, сахилгын шийтгэлтэй албан хаагчид үр дүнгийн урамшуулал олгосон зэрэгтэй холбоотой зөрчил нь аймгийн засаг даргын дэргэдэх санхүүгийн хяналт, аудитын албаны зөрчил төлбөртэй давхардсан болно.

Санхүүгийн хяналт, аудитын алба 2017 оны санхүүгийн үйл ажиллагаанд шалгалт хийж 7,3 сая төгрөгийн нөхөн төлбөр тавьсан байна.

Мөн тус сургуулийн үйл ажиллагаатай холбоотой иргэний өргөдөл ирсэн бөгөөд уг асуудлыг санхүүгийн хяналт-аудитын алба, цагдаагийн эдийн засгийн алба шалгасан тул дүгнэлт өгөөгүй болно.

ЕБС нь батлагдсан орон тоогоор ажилласан байна.

ЕБС нь 2017 онд нийт 53 орон тоотой ажилласан бөгөөд удирдах 1, гүйцэтгэх 28, үйлчлэх 12, гэрээт 12 байгаа нь батлагдсан орон тоо байна.

Боловсон хүчний цалин тогтоолтыг судлан үзэхэд алдаа зөрчил илрээгүй бөгөөд албан хаагчдын цалин нь үндсэн цалин, зэргийн нэмэгдэл, ур чадварын нэмэгдэл, орон нутгийн нэмэгдэл, анги даалт, заах аргын нэмэгдэл зэрэг нэмэгдлүүдээс бүрдсэн байна.

ЕБС-ийн багшлах боловсон хүчний 5 нь магистер зэрэгтэй, 11 нь заах аргач мэргэжлийн зэрэгтэй, 9 нь тэргүүлэх зэрэгтэй, 1 нь зөвлөх байгаа нь боловсон хүчин бэлтгэгдсэн байна гэж үзэхээр байна.

Боловсон хүчний хөдлөлийн тайлантай танилцахад шилжилт хөдөлгөөн байхгүй байгаагаас үзэхэд ЕБС-ийн боловсон хүчин нь тогтвор суурьшилтай ажиллаж байна.

Няравын тайлан гаргалтанд анхаарч, түүний гаргасан тайланд үндэслэн бvртгэл хөтлөж хэвших шаардлагатай байна.

Шилүүстэй сумын төсөвт байгууллагуудын 2017 оны үйл ажиллагааны үр дүн

2017 онд ЕБС-д ДЗОУБ-ын хөрөнгө оруулалтаар 57,0 сая төгрөгийн өртөг бүхий сурагчдын био-оо, боловсрол соёл шинжлэх ухааны сайдын хөрөнгө оруулалтаар 11,6 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга, ном нийлүүлэгдсэнийг данс бүртгэлд тусган, үйл ажиллагаандаа ашиглаж байна.

ЕБС нь 2017 онд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн төвд 9,9 сая төгрөгийн хөрөнгө болон бараа материал нийлүүлэгдэхээс 3,2 сая төгрөгийн хөрөнгө дутуу байхад баримтын дүнгээр орлого авсан зөрчил байна.

Мөн байгууллагын данс бүртгэлд байгаа 1,8 сая төгрөгийн 16 ш ор, 0,7 сая төгрөгийн 12ш гудсыг аймгийн төвд хувь хүнд ашиглуулж байгаа зөрчил байна.

Дээрх зөрчлийг арилгуулах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэлээ.

Байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад зориулагдсан бараа материалыг худалдан авч данс бүртгэлд тусган ажиллаж байгаа хэдий ч үдийн цай хөтөлбөрт зарцуулагдсан хүнсний материалыг шууд зардлаар зарцуулсан алдаа байгаад зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Үдийн цай болон дотуур байрны хүүхдийн хоолонд зориулан худалдан авсан хүнсний материалыг няравын тайлантай тулган үзэхэд материалын тайланд орлого авалгүй шууд зарцуулсан 1,2 сая төгрөгийн зөрчил илэрсэн болно.

Нягтлан бодогч тайлангаа гаргахдаа няравын тайланд үндэслэн данс бүртгэл хөтөлдөггүй, няравын үйл ажиллагаанд хяналт тавьдаггүй, зааж сургадаггүй, ажлын хоорондын уялдаа холбоо байхгүй зэрэг дутагдал байна гэж үзлээ.

Мөн хүнсний материалыг их хэмжээгээр урьдчилан бэлтгэдэг нь аудитын явцад ажиглагдсан бөгөөд хүнсний материалын үлдэгдэл 16,1 сая төгрөг байгаа үүнийг харуулж байна. Цаашид хүнсний аюулгүй байдалд анхаарч, үдийн цай болон дотуур байрны хүүхдийн хоолны материалыг бэлтгэхдээ ашиглах хугацаа, норм нормативд үндэслэн бэлтгэж, хүнсний худалдаа эрхлэгчидтэй гэрээ байгуулан ажиллах нь зүйтэй байна.

Цаашид няравын тайлан гаргалтанд анхаарч, түүний гаргасан тайланд үндэслэн бүртгэл хөтлөж хэвших шаардлагатай байна.

❖ **ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН:**

Хүүхдүүдийн ая тухтай орчин бүрдэх 100 хүүхдийн хүчин чадал бүхий шинэ цэцэрлэгийн барилга баригдах төсөв батлагджээ.

Шилүүстэй сумын төсөвт байгууллагуудын 2017 оны үйл ажиллагааны үр дүн

Монгол Улсын “Сургуулийн өмнөх боловсролын тухай” хуулийн 3 дугаар бүлгийн 3.1 дүгээр зүйлд СӨБ-ийн зорилго нь “Бага насны хүүхдийг асрах, хамгаалах, хүмүүжүүлэх, сургах цогц үйл ажиллагаагаар хүүхдийн бие бялдар, оюун ухаан, нийгэмшихүйн хөгжлийг дэмжих, сургуульд бэлтгэхэд оршино” гэж энэ байгууллагын үйл ажиллагааны зорилгыг тодорхойлсон байна.

2017 оны үр дүгийн гэрээнд 32 асуудал хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд 16 асуудал 100%, 11 асуудал 70%, 1 асуудал 40%-тай хэрэгжиж, 4 асуудал хэрэгжээгүй нийт 84.3%-тай ажлаа дүгнүүлж “70” буюу “СЗ үнэлгээг авсан байна.

Цэцэрлэгийн хайс, хамгаалалтын 10000.0 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлыг дуусгаж хүлээж авсан байна.

Харин хэрэгжээгүй ажлуудыг дурдвал: Туслах үйл ажиллагаанаас орлого олох

- ❖ Технологийн бүтээлийн санд бүртгүүлсэн бүтээлийн тоо
- ❖ Мэргэжлийн зэрэгтэй багштай болох зэрэг ажлууд байгаа бөгөөд 2018 онд зарим ажлууд хэрэгжиж эхэлсэн байна.

Тус цэцэрлэг нь 50 хүүхэд хүлээж авах хүчин чадалтай бөгөөд бодит байдалд 70-100 хүүхэд хүлээн авч ажиллаж байгаа бөгөөд 2018 оны Төсвийн хууль, аймаг, сумын засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх 2017-2018 оны үндсэн чиглэлд суугдан 100 хүүхдийн хүчин чадал бүхий шинэ цэцэрлэгийн барилга баригдах төсөв батлагдсан хүүхдүүдийн ая тухтай орчин бүрдэх ажил хийгдэх гэж байна.

Цаашид төлөвлөсөн ажил нэг бүрийг хэрэгжүүлэх чигэлэлээр анхаарч ажиллах шаардлагатай гэж үзлээ.

Нярав орлого зарлагын тайланг тогтсон стандартын дагуу гаргадаггүй, сарын эцэс болгонд тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулдаггүй дутагдал нийтлэг болсон байна.

Цэцэрлэг нь 2017 онд улсын төсвөөс авах 178913.4 мянган төгрөгийн санхүүжилт авахаас 178892.9 мянган төгрөгийн санхүүжилтыг бүрэн авч зарцуулсан байна.

Цэцэрлэгийн төсвийн зарцуулалтыг нягталж үзэхэд: Бүх зардлуудыг батлагдсан төсийн хүрээнд зориулалтын дагуу зарцуулсан бөгөөд аудитын шалгалтаар зөрчил илрээгүй болно.

Шилүүстэй сумын төсөвт байгууллагуудын 2017 оны үйл ажиллагааны үр дүн

Харин аймгийн ЗДТГ-ын дэргэдэх санхүүгийн дотоод аудитын алба 2018 оны эхний улиралд хяналт хийж эрхлэгч ажил дүгнэсэн материал, захирамж шийдвэргүйгээр урамшуулал авсан 1266.5 мянган төгрөгийн нөхөн төлбөр ногдуулсан байна.

Төсвийн зарцуулалттай холбоотой зөрчил илрээгүй ч хүүхдийн хоолны зардлын зарцуулалттай холбоотой дараахь анхаарах зөрчлүүд илэрч байна. Үүнд:

2017 оны хоолны 27502.0 мянган төгрөгийн орлого, эхний 4 сарын хоолны зарцуулалтыг нэг бүрчлэн тулган шалгахад

- Нийт дүнгээрээ төмс, хүнсний ногоог орлогод орхигдуулсан
- Мөнгөн дүнг программд шивж оруулахдаа дүнг зөрүүтэй шивдэг
- Цэцэрлэгт ирсэн хүүхдийн ирц, тогоочийн материал нэхэмжилсэн хүүхдийн тоотой зөрүүтэй
- Няравын хоолны материалын зарлагын тайлангаарх хүүхдийн тоо бодит хүүхдийн тоотой зөрүүтэй зөрчлүүд нийтлэг гарч байна.

Дээрхи байдлаас дүгнэлт хийхэд өглөө ирсэн хүүхдийн тоог эрхлэгч баталгаажуулж тогооч, нярав нарт өгдөггүй, няравын хоолны материал авч байгаа хүүхдийн тоог хянадаггүй зэрэгтэй холбоотойгоор хүүхдийн тоог тухайн өдрийн бодит тооноос илүү, дутуу хоолны материалыг нийлүүлж байна.

Дээрх шалтгаанууд нөлөөлж сарын хоолны зарлага нэр төрөл дээр илүү, дутуу зарлага гардаг явдал хавтгайрсан байна.

Мөн нярав орлого зарлагын тайланг тогтсон стандартын дагуу гаргадаггүй, сарын эцэс болгонд тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулдаггүй дутагдал нийтлэг байна.

Бараа, хүнсний материалуудыг зарлага болгохдоо нягтлан бодох бүртгэлийн өртгийн аргуудын эхэлж авснаа эхэлж зарлага болгох аргыг баримтлан зарцуулалтын тайлан гаргаж байх шаардлагатай байна.

Аудитын явцын ажиглалтаас үзэхэд эрхлэгч, нягтлан бодогч, нярав, тогооч нарын хоорондын ажлын уялдаа хангалтгүй байгаа нь санхүүгийн зөрчил гарахад нөлөөлж байна гэж үзэх үндэстэй байна.

Дээрх аргаар бүртгээгүйгээс зарим материалын үнэ хүрэлцэхгүй болох, эсвэл үнэ дууссан материал үлдэх сөрөг үр дагаврууд гарч болох эрсдэлд анхаарч өгсөн зөвлөмжийн дагуу няравын тайланг гаргаж үе шатны хяналтыг хийлгэн бүртгэлийг үнэн зөв тайлагнаж байх шаардлагатай гэж үзлээ.

Цалингийн сан бодит байдалтай уялдан төлөвлөгдсөн байна.

Шилүүстэй сумын төсөвт байгууллагуудын 2017 оны үйл ажиллагааны үр дүн

Тус цэцэрлэг удирдах 1, гүйцэтгэх 11, үйлчилгээний ажилтан 4, нийт 16 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулсан байна.

2017 онд цалин болон нэмэгдэл урамшууллын зардалд 107150.0 мянган төгрөг батлагдсан бөгөөд гүйцэтгэлээр 107123.8 мянган төгрөг зарцуулж 26.8 мянган төгрөгийн хэмнэлттэй зарцуулсан байна. Цалингийн зарцуулалтыг хянахад Засгийн газрын 2007 оны 354 дүгээр тогтоол, 2013 оны 332-р тогтоолын дагуу зөв хуваарилан олгогджээ.

Хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, хөрөнгө оруулалт төсөл хөтөлбөрөөр хийгдсэн ажлын үр дүн сайн байна.



Цэцэрлэгт 2017 онд хийгдсэн хайс, хамгаалалтын 10000.0 мянган төгрөгийн хөрөнгийг аудитаас өгсөн зөвлөмжийн дагуу бүртгэлд тусгасан ба бусад хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаж бүртгэсэн бөгөөд хөрөнгийн



хадгалалт хамгаалалт, эмх цэгц сайн хөрөнгийн тооллого хийж, тооцоо бодон ажилласан байна.

Тус цэцэрлэгийн санхүүгийн тайланд 653,0 мянган төгрөгийн авлага байгааг судалж үзэхэд 2016 онд эрхлэгч А.Бямбасүрэнгийн урьчилгаа цалингийн үлдэгдэл 700,0 мянган төгрөг, багш Т.Баднайсүрэнгийн урьдчилгаа цалингийн үдэгдэл 857,5 мянган төгрөг нийт 1557,5 мянган төгрөгийг авлага үүсгэх ёстойг 1353,0 мянган төгрөгөөр үүсгэж 204.5 мянган төгрөгөөр дутуу үүсгэсэн байна.

Т.Баднайсүрэнд олгосон цалингийн 2000,0 мянган төгрөгийн урьдчилгаа цалин олгосон бөгөөд 2016 оны 10 сарын цалингаас 500,0 мянган төгрөгийг, 12 сард 642,5 мянган төгрөгийг, 2017 оны 07 сард 704,4 мянган төгрөгийг тус тус суутган тооцоо хийж 153.1 мянган төгрөгийг дутуу суутган орхигдуулсныг төлбөрийн акт тогтоохоор шийдэврэлэв. Тайлан баланст суутган тооцоо хийж дууссан 653,0 мянган төгрөгийг үр дүнгийн тайлангийн өмнөх үеийн үр дүнд хааж бүртгэлийг эрүүлэх шаардлагатай байна./ *А.Бямбасүрэнгийн урьчилгаа цалингийн үлдэгдэл 700,0 мянган төгрөгийг суутгаж дууссан байна./*

❖ СОЁЛЫН ТӨВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН:

Соёлын төв үр дүнгийн гэрээгээ 76%-тай дүгнүүлсэн нь шаардлагын хэмжээнд хүрээгүй байна.

Шилүүстэй сумын төсөвт байгууллагуудын 2017 оны үйл ажиллагааны үр дүн

Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг нийгмийг хөгжүүлэх 2017 оны үндсэн чиглэлд 4 төрлийн арга хэмжээ хэрэгжүүлэхээр тусгасныг бүрэн хэрэгжүүлсэн байна. Мөн өөрийн төлөвлөгөө хөтөлбөрийн хүрээнд 4 бүлэг 50 төрлийн арга хэмжээ төлөвлөснөөс 38 төрлийн арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, 12 арга хэмжээ хэрэгжээгүй бөгөөд төлөвлөгөөний биелэлт 76 хувийн хэрэгжилттэй гарсан байна. Үүнээс: 90-100 хувийн гүйцэтгэлтэй 28, 70-80 хувийн гүйцэтгэлтэй 14, 70-с доош хувийн гүйцэтгэлтэй 6 арга хэмжээ, 0-хувиар дүгнэгдсэн 2 арга хэмжээ байна.

Соёлын төв үр дүнгийн гэрээгээ 76%-тай дүгнүүлсэн нь шаардлагын хэмжээнд хүрээгүй байна.

Хэрэгжилт нь 70 хувиар дүгнэгдсэн ажил үйлчилгээг тодруулахад үе шаттайгаар дараагийн жилүүдэд хэрэгжих буюу тодорхой шалтгааны улмаас гүйцэтгэл, үр дүн нь бүрэн гараагүй арга хэмжээнүүд байна.

Харин хэрэгжилт нь 0 хувиар дүгнэгдсэн ажил үйлчилгээний хувьд хэрэгжих боломжгүй буюу хөрөнгө санхүүгийн эх үүсвэртэй холбоотой ажил төлөвлөсөнтэй холбоотой байна.

Тус байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан ажил үйлчилгээнүүд нь хэт нуршсан, асуудлыг жижигрүүлж задалсан, хэрэгжих боломжгүй буюу хөрөнгө эх үүсвэр нь тодорхой биш, утга санаа давхардсан ажил үйлчилгээг тусгасан дутагдал байна.

Цаашид үйл ажиллагааны төлөвлөгөөг гаргахдаа холбогдох хуулинд заасан үүрэг, оролцоог үндэслэн, хэрэгжих боломжтой үр нөлөөтэй ажил үйлчилгээг тусгах шаардлагатай байна гэж үзлээ.

Өөрийн орлогын төлөвлөгөөг сар тутам жигд биелүүлээгүй 11,12-р саруудад орлогын төлөвлөгөө тасарсан байна.

А. 2017 оны орлого бүрдүүлэлтийн байдлыг хүснэгтээр харуулбал:

№	Он сар	Орлогын дүн сараар
1	2017-01	276500
2	2017-02	114500
3	2017-03	71500
4	2017-04	51000
5	2017-05	139000
6	2017-06	20500

**Шилүүстэй сумын төсөвт байгууллагуудын 2017 оны үйл
ажиллагааны үр дүн**

7	2017-07	149500
8	2017-08	64500
9	2017-09	64500
10	2017-10	77500
	Нийт дүн	1029000

2017 онд батлагдсан санхүүжилтээ бүрэн авч, өөрийн орлогоор 1029.0 мянган төгрөг төвлөрүүлж нийт 56029,2 мянган төгрөгийн санхүүжилттэй ажилласан байна.

Тус байгууллага нь 56029,2 мянган төгрөгийн зарлагатай ажиллаж 2105,4 мянган төгрөгөөр зардлыг хэтрүүлэн ажилласан байна.

Зардлын зүйлийг эдийн засгийн ангилалаар нь авч үзэхэд:

д/д	Зардлын зүйл	Төлөв лөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт	Хэмнэлт
1	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	36975,0	39705,2	-2730,2	
2	НДШ	4067,4	4424,3	-356,9	
3	Гэрэл цахилгаан	680,2	278,7		401,4
4	Түлш халаалт	7350,0	5218,5		2131,5
5	Цэвэр бохир ус	30,0	10,0		20,0
6	Бичиг хэрэг	66,5	109,2	-42,7	
7	Тээвэр шатахуун	150,0	137,0		13,0
8	Шуудан холбоо	154,3	316,5	162,2	
9	Ном хэвлэл	60,0	20,0		40,0
10	Бага үнэтэй түргэн элэгдэх эд зүйлс	60,0	394,5	334,5	
11	Урсгал засвар	150,0	150,0		
12	Томилолт	80,0	77,8		2,1
13	Нормын хувцас зөөлөн эдлэл	40,0			40,0
14	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж	1600,0	1276,8		323,1
15	Тэтгэвэрт гархад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж.	2380,4	2380,4	0	0
16	Нэг удаагийн тэтгэмж	1500,0	1500,0	0	0

Хэтэрсэн болон хэмнэгдсэн зардлууд нь дараах шалтгаантай байна.

Шилүүстэй сумын төсөвт байгууллагуудын 2017 оны үйл ажиллагааны үр дүн

- Цалин хөлс болон нэмэгдэл урамшилын зардлыг 2730,2 мянган төгрөгөөр хэтрүүлсэн нь Соёлын төвийн 3-н галчийн орон тоо батлагдсантай холбоотой .
- НДШ-ийн зардлыг 356,9 мянган төгрөгөөр хэтрүүлсэн шалтгаан нь цалингийн сан хэтэрсэнээс.
- Түлш халаалтын зардал 2131,5 мянган төгрөгөөр хэмнэсэн нь өмнөх оны түлээний модны үлдэгдэл нөлөөлсөн .
- Бага үнэтэй түргэн элэгдэх эд зүйлсийн зардал 334,5 мянган төгрөгөөр хэтэрсэн

Аудитаар төсвийн зарцуулалттай холбоотой дараах зөрчил илрүүлээ.

- Жолоочийн замын хуудсаарх тооцоог бодоогүй, автомашины шатахуун зарцуулалтын хэтрэлт хэмнэлтийг тооцдоггүй, шатахуун зарцуулалтад бүртгэлээр тавих хяналт байхгүй 325,0 мянган төгрөгийг зарцуулсан.
- Баримтын бүрдүүлэлт дутуу, дуудсан бичиггүйгээр томилолтын зардал 2810.0 мянган төгрөгийг зарцуулсан.
- 3-н галчийн орон тоо батлагдаж Түлш халаалтын зардлаас Нийгмийн даатгалын шимтгэл 1253,4 мянган төгрөгийг олгосон зэрэг нийт 4388,4 мянган төгрөгийн зөрчил илрүүлээ.

Соёлын төв нь 2017 онд нийт 8 орон тоотой ажилласан бөгөөд удирдах 1, гүйцэтгэх 3, үйлчлэх 4, байгаа нь батлагдсан орон тоо байна.

2017 онд цалин болон нэмэгдэл урамшууллын зардалд 36975,0 мянган төгрөг батлагдсан бөгөөд гүйцэтгэлээр 39705.2 мянган төгрөг зарцуулж 2730,2 мянган төгрөгийн хэтрүүлэн зарцуулсан байна.

Цалингийн зарцуулалтыг хянахад Засгийн газрын 2007 оны 354 дүгээр тогтоол, 2013 оны 332-р тогтоолын дагуу зөв хуваарилан олгогджээ.

Хөрөнгийн хадгалалт хамгаалалт, ашиглалт , эмх цэгц сайн байна.

Аудитын явцад хөрөнгийн худалдан авалт, ашиглалт, хадгалалт, хамгаалалтын байдалтай газар дээр нь танилцаж, хэсэгчилсэн тооллого хийлээ.

Хэсэгчилсэн тооллогоор хөрөнгийн дутагдал гараагүй болно.

Байгууллагын тавилга эд хогшил, тоног төхөөрөмжүүдийг эзэмшиж буй ажилтнууд дээр карталж эзэмшүүлсэн байна.

2017 онд Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын яамнаас болон хандив тусламжаар 1065,8 мянган төгрөгийн ном өгсөнийг орлогод бүрэн тусгаж, ашиглаж

Шилүүстэй сумын төсөвт байгууллагуудын 2017 оны үйл ажиллагааны үр дүн

байна. Тус байгууллагын үндсэн хөрөнгийн номын фондод 2004 онд дахин үнэлгээ хийсэн байна.

Дээрхи үнэлгээгээр номын фонд зөрүүтэй, мөн актлах номнуудыг программд жагсаалтаар бүртгээгүйтэй холбоотой нийт 5648,5 мянган төгрөгийн зөрүү гарсан нягтлах зөвлөмж өглөө.

Мөн байгууллагын бүртгэлд байгаа боловч, анхны өртгөөрөө элэгдэлээ бүрэн нөхсөн, цаашид ашиглах боломжгүй болсон хөрөнгийн жагсаалтыг гарган актлуулах шийдвэр гаргуулахаар холбогдох газарт хүргүүлсэн байна.

Нягтлан бодогч тайлангаа гаргахдаа няравын тайланд үндэслэн данс бүртгэл хөтөлдөггүй, няравын үйл ажиллагаанд хяналт тавьдаггүй, зааж сургадаггүй, ажлын хоорондын уялдаа холбоо байхгүй зэрэг дутагдал байгаад анхаарч ажиллах шаардлагатай байна.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН:

Тус байгууллага нь үйл ажиллагааны төлөвлөгөөндөө хуулиар хүлээсэн үүргээ бүрэн тусгаж, зорилго зорилтоо үнэн зөв тодорхойлжээ.

Тус байгууллага нь сумын Эдийн засаг нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд 4 төрлийн арга хэмжээ тусгаж бүрэн хэрэгжүүлсэн байна. Мөн үйл ажиллагааны төлөвлөгөөндөө 7 бүлэг 36 асуудал төлөвлөснөөс 29 ажил бүрэн хэрэгжиж 7 төрлийн ажил хэрэгжээгүй бөгөөд төлөвлөгөөний биелэлт 80,5 хувийн хэрэгжилттэй ажилласан байна.

Аудитын явцад хэрэгжсэн ажлуудыг газар дээр нь үзэж дүгнэлт хийхэд ажлууд хангалттай хийгдсэн байна. Хийгдсэн ажлуудын үр дүнгээс дүгнэхэд дэвшүүлсэн зорилтоо бүрэн хэрэгжүүлсэн үйл ажиллагаа жигд явагдаж байна.

Сум дундын эмнэлэг нь үйл ажиллагааны төлөвлөгөөнд эмнэлэгийн тусламж үйлчилгээтэй холбоотой хэт нуршсан, асуудлыг жижигрүүлж задалсан, хэрэгжих боломжгүй буюу хөрөнгө эх үүсвэр нь тодорхой биш, утга санаа давхардсан ажил үйлчилгээг тусгасан дутагдал байна.

Цаашид хэрэгжээгүй буюу хэрэгжих шатандаа байгаа асуудлуудад дүгнэлт хийж тодорхой ажил зохион байгуулах шаардлагатай гэж үзлээ.

Түлш халаалт, тээвэр шатахууны зардлуудын зарцуулалтанд тавих хяналтыг сайжруулж, зардал хямдруулах талаар тодорхой ажил зохион байгуулах шаардлагатай байна.

Шилүүстэй сумын төсөвт байгууллагуудын 2017 оны үйл ажиллагааны үр дүн

2017 онд батлагдсан санхүүжилтээ бүрэн авч, нэмэлт санхүүжилтээр 1000,0 мянган төгрөгийн, урсгал үйл ажиллагааны санхүүжилт 5629,1 мянган төгрөгийн, нийт 298055,1 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлэн ажилласан байна.

Тус байгууллага нь тайлант хугацаанд 298055,1 мянган төгрөгийн зарлагатай үйл ажиллагаа явуулж 1419,9 мянган төгрөгийн төсвийн хэмнэлттэй ажилласан байна.

Зардлын зүйлийг эдийн засгийн ангилалаар нь авч үзэхэд:

д/д	Зардлын зүйл	Төлөв лөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт	Хэмнэлт
1	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	194475,9	195253,1	-777,2	
2	НДШ	22327,4	21513,2		814,1
3	Гэрэл цахилгаан	1333,4	1548,4	-215,0	
4	Түлш халаалт	13236,8	13411,6	-174,8	
5	Цэвэр бохир ус	434,3	44,4		389,9
6	Бичиг хэрэг	398,4	317,4		81,0
7	Тээвэр шатахуун	11187,2	11259,2	-71,9	
8	Шуудан холбоо	126,0	66,0		60,0
9	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	326,1	55,0	0	271,1
10	Бага үнэтэй түргэн элэгдэх эд зүйлс	436,6	699,3	-262,7	
11	Эм бэлдмэл эмнэлэгийн хэрэгсэл	19068,8	18954,4	0	114,3
12	Хоол хүнс	6378,1	7197,5	-819,4	
13	Нормын хувцас зөөлөн эдлэл	1732,4	1027,5	0	704,9
14	Багаж техник хэрэгсэл	346,5		0	346,5
15	Урсгал засвар	5336,6	5846,5	-509,9	
16	Томилолт	565,5	610,2	-44,7	
17	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж	2085,9	1368,5	0	717,3
18	Бараа үйлчилгээний бусад зардал	4950,0	4153,4	0	796,5
19	Нэг удаагийн тэтгэмж	8100,0	8100,0	0	0

Хэтэрсэн болон хэмнэгдсэн зардлууд нь дараах шалтгаантай байна.

Шилүүстэй сумын төсөвт байгууллагуудын 2017 оны үйл ажиллагааны үр дүн

- Цалингийн зардал 777,2 мянган төгрөгөөр хэмнэсэн шалтгаан нь мэсийн эмч, эмэгтэйчүүдийн эмч хагас жилээс хойш ажиллаагүйтэй
- Түлш халаалтын зардал 174,8 мянган төгрөгөөр хэтэрсэн төлөвлөгөө бодит байдалтай уялдаагүй зардал хүрэлцдэггүйтэй .
- Хоол хүнсний зардал 819,4 мянган төгрөгөөр хэтэрсэн нь өвлийн улиралд өвчлөл их ачаалал их байсантай холбоотойгоор
- Бага үнэтэй түргэн элэгдэх эд зүйлс 262,7 мянган төгрөгөөр хэтэрсэн нь төлөвлөсөн зардлыг бодит хэмжээгээр баталдаггүйтэй холбоотой байна.
- Урсгал засвар 509,9 мянган төгрөгөөр хэтэрсэн нь 3-н өрөөнд иж бүрэн засвар хийсэнтэй холбоотойгоор зардлууд хэтэрсэн байна.

Тус онд авлага барагдуулах талаар тодорхой ажил зохион байгуулаагүй байна.

Тус байгууллага нь ажилчидтай холбоотой 3774,6 мянган төгрөгийн авлага, хүн амын орлогын албан татвар, НИС ХХК, эргэлтийн эмийн сан зэрэг газруудаас 5098,5 мянган төгрөгийн авлага, хувь хүмүүсээс 1472,7 мянган төгрөгийн авлага зэрэг нийт 10345,9 мянган төгрөгийн авлагтай байна.

Аудитаар төсвийн зарцуулалттай холбоотой дараах зөрчил илрүүлээ.

- Автомашины шатахуун зарцуулалтын хэтрэлт хэмнэлтийг тооцдоггүй, шатахуун зарцуулалтад бүртгэлээр тавих хяналт сул, спидометрийн заалтыг бүрэн бичдэггүй зөрчил байна.
- Баримтын бүрдүүлэлт дутуу 4733,2 мянган төгрөгийн зардал гаргасан.
- Дуудсан бичиггүй 116,0 мянган төгрөгийн томилолтын зардал гаргасан.
- Эрхлэгч эмч Захирамжгүйгээр ажил хавсарсаны нэмэгдэл 259,9 мянган төгрөг авсан.
- Үндсэн баримтгүй 2267,2 мянган төгрөг зарцуулсан зэрэг нийт 7376,5 мянган төгрөгийн зөрчил илрүүлээ.

Авлагыг барагдуулах талаар тодорхой ажил зохион байгуулж үр дүнг тооцох хариуцлага тооцож ажиллах шаардлагатай байна.

2017 онд батлагдсан орон тооноос 3 орон тоо илүү ажилласан байна

2017 онд тус байгууллага нь батлагдсан 25 орон тоотой байхад 28 орон тоотой үйл ажиллагаа явуулсан байна.

Шилүүстэй сумын төсөвт байгууллагуудын 2017 оны үйл ажиллагааны үр дүн

Үүнд удирдах ажилтан 1, гүйцэтгэх ажилтан 19 батлагдсанаас 21 ажилтан ажиллаж 2 орон тоо илүү байна, үйлчлэх 5 орон тоо батлагдсан байхад 6 ажилтан ажиллаж 1 орон тоо илүү байгаа зөрчил байна.

Аудитын явцад цалин тогтоолтыг шалган үзэхэд Засгийн газрын 2014 оны 75 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтын дагуу тогтоосон байна.

Хөрөнгийн хадгалалт хамгаалалт, эмх цэгц сайн байна.

Аудитын явцад хөрөнгийн худалдан авалт, ашиглалт, хадгалалт, хамгаалалтын байдалтай газар дээр нь танилцаж, хэсэгчилсэн тооллого хийлээ.

Хэсэгчилсэн тооллогоор хөрөнгийн дутагдал гараагүй болно.

Байгууллагын тавилга эд хогшил, тоног төхөөрөмжүүдийг эзэмшиж буй ажилтнууд дээр карталж эзэмшүүлсэн байна.

2017 онд Бурам мишээл ХХК-аас 74658,6 мянган төгрөгийн мэс заслын тоног төхөөрөмж, 24567,7 мянган төгрөгийн тавилга хэрэгсэл нийт 99226,3 мянган төгрөгийн хөрөнгө хандиваар авсан, Мөн ИТХ-ын шийдвэртэйгээр төсвийн хөрөнгөөр 1009,8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 1626,0 мянган төгрөгийн тавилга хэрэгсэл зэрэг нийт 101882,1 мянган төгрөгийн хөрөнгө ирсэнийг орлогод бүрэн тусгасан байна.

Тус байгууллага нь мэс заслын эмч байхгүйтэй холбоотой дээрхи ирсэн тоног төхөөрөмж, тавилга хэрэгслүүдийг ашиглаж чадахгүй, мэс заслын үйлчилгээ үзүүлж чадахгүй байна.

Шилүүстэй сумын төсөвт байгууллагуудын 2017 оны үйл ажиллагааны үр дүн

ЗӨВЛӨМЖ

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
дарга Г.Ууганбаяр-д

Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2018 оны А/06 дугаар тушаалаар батлагдсан “ Үндэсний аудитын газрын 2018 онд гүйцэтгэх аудитын сэдвийн төлөвлөгөө”-г үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд дарга, тэргүүлэх аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу сумын төсөвт байгууллагуудын 2017 оны үйл ажиллагааны үр дүнд хийгдсэн гүйцэтгэлийн аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.

1. Сумын засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг 2018-2019 онуудад хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдах асуудлуудыг ач холбогдлоор нь эрэмбэлж, хэрэгжих магадлалтай асуудлуудыг баталж байх
2. Жолоочийн замын хуудас бичүүлж шатахууныг зарцуулалтыг гаргах, үндсэн баримтын бүрдэлгүй ажил гүйлгээ гаргадаг байдлыг таслан зогсоох .

Гүйцэтгэлийн аудитаар өгөгдсөн зөвлөмжийн биелэлтийн хариуг 2018 оны 09 сарын 25-ны дотор албан тоотоор ирүүлэхийг мэдэгдье.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Л.УЛАМБАЯР

Шилүүстэй сумын төсөвт байгууллагуудын 2017 оны үйл ажиллагааны үр дүн

ЗӨВЛӨМЖ

Шилүүстэй сумын засаг дарга Д.Алтанжаргал-д

Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2018 оны А/06 дугаар тушаалаар батлагдсан “ Үндэсний аудитын газрын 2018 онд гүйцэтгэх аудитын сэдвийн төлөвлөгөө”-г үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд дарга, тэргүүлэх аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу сумын төсөвт байгууллагуудын 2017 оны үйл ажиллагааны үр дүнд хийгдсэн гүйцэтгэлийн аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.

1. Үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг жил бүр олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлж байх
2. Засаг даргын үйл ажиллагааны хуульд заасан хугацаанд хяналт-шинжилгээ, хөндлөнгийн үнэлгээ хийлгэж, ажлын тайланг баримтжуулж, мэдээлэх
3. Цаашид хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн эх үүсвэрийг бодитой тооцоо судалгаанд үндэслэн төсөөлөл хийж байх
4. Сумын халуун усны барилга, ЗДТГ-ын буудлын барилгуудын халаалтын асуудлуудыг тодорхой үе шаттайгаар санхүүжүүлэн ажилд оруулан сумын иргэдийн ая тухтай орчин бүрдүүлэх, ажлын байр бий болох боломжуудыг судлан гүйцэтгэх
5. Татварын орлогуудын төлөвлөгөөг бүх нэр төрөл дээр жигд биелүүлэх ажилд сумын удирдлагууд, татварын байцаагч нар тодорхой ажил зохион байгуулж үр дүнг тооцох
6. “Хүйн холбоо буюу цагийн эрхээр харьд одсон монгол эрийн цадиг хуучин хэлхээ оршивой” номын үлдэгдлийн зарж борлуулах, төсөвт байгууллагуудаас авах номын үнийг гаргуулан байгууллагын дансанд төвлөрүүлэх
7. Түлш халаалт, тээвэр шатахууны зардлуудын зарцуулалтанд тавих хяналтыг сайжруулан зардал хямдруулах талаар тодорхой ажил зохион байгуулах
8. Замын хуудсанд үйлчилгээний машины спидометрийн заалтыг бүрэн бичүүлж ажил үйлчилгээнд унаж явсан албан тушаалтаны хүлээн зөвшөөрсөн гарын үсгийг зуруулан тээвэр шатахууны зардлын гүйцэтгэлийг хянан сар бүр жолоочийн тооцоог бодож МУ-ын Засгийн газрын 2007 оны 349-р тогтоолыг хэрэгжүүлэх шатахууны хэтрэлт хэмнэлтийн тооцоог хийж байх

Гүйцэтгэлийн аудитаар өгөгдсөн зөвлөмжийн биелэлтийн хариуг 2018 оны 09 сарын 25-ны дотор албан тоотоор ирүүлэхийг мэдэгдье.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Л.УЛАМБАЯР

Шилүүстэй сумын төсөвт байгууллагуудын 2017 оны үйл ажиллагааны үр дүн

ЗӨВЛӨМЖ

Шилүүстэй сумын ерөнхий боловсролын сургуулийн
захирал А.Гарамсүрэн-д

Монгол улсын Ерөнхий аудиторт нийлүүлэх бүтээгдэхүүн ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Отгон сумын төсөвт байгууллагуудын 2017 оны үйл ажиллагааны үр дүнд дүгнэлт өгөх гүйцэтгэлийн аудитаар ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагаанд илэрсэн алдаа зөрчилд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

1. Үдийн цайнд олгох хүнсний материалыг бараа материалын тайланд тусгах
2. Нягтлан бодогч, нярав нарын ажлын уялдааг сайжруулан, бараа материалын тайланг сар бүр гаргах
3. Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй мөртлөө бусдын эзэмшилд байгаа тавилгыг өөрийн эзэмшилд эргүүлэн авах

Аудитаар өгөгдсөн зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 09 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Л.УЛАМБАЯР

Шилүүстэй сумын төсөвт байгууллагуудын 2017 оны үйл ажиллагааны үр дүн

ЗӨВЛӨМЖ

Шилүүстэй сумын Цэцэрлэгийн эрхлэгч Ц.Бямбасүрэн-д

Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2018 оны А/06 дугаар тушаалаар батлагдсан “ Үндэсний аудитын газрын 2018 онд гүйцэтгэх аудитын сэдвийн төлөвлөгөө”-г үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд дарга, тэргүүлэх аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу сумын төсөвт байгууллагуудын 2017 оны үйл ажиллагааны үр дүнд хийгдсэн гүйцэтгэлийн аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.

1. Бараа, хүнсний материалуудыг зарлага болгохдоо нягтлан бодох бүртгэлийн өртгийн аргуудын эхэлж авснаа эхэлж зарлага болгох аргыг баримтлан зарцуулалтын тайлан гаргаж байх
2. Няравын орлого зарлагын тайланг тогтсон стандартын дагуу гаргуулж сар бүрийн эцэст тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулж хэвших.

Аудитаар өгөгдсөн зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 09 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Л.УЛАМБАЯР

Шилүүстэй сумын төсөвт байгууллагуудын 2017 оны үйл ажиллагааны үр дүн

ЗӨВЛӨМЖ

Завхан аймгийн Шилүүстэй сумын Соёлын төвийн эрхлэгч
Эрхлэгч П.Пагмасүрэн-д

Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2018 оны А/06 дугаар тушаалаар батлагдсан “ Үндэсний аудитын газрын 2018 онд гүйцэтгэх аудитын сэдвийн төлөвлөгөө”-г үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд дарга, тэргүүлэх аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу сумын төсөвт байгууллагуудын 2017 оны үйл ажиллагааны үр дүнд хийгдсэн гүйцэтгэлийн аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.

3. Өөрийн орлогын төлөвлөгөөг сар бүрээр жигд биелүүлэх, орлого нэмэгдүүлэх талаар тодорхой ажил зохион байгуулах
4. Актлах номнуудыг программд жагсаалтаар бүртгээгүйтэй холбоотой нийт 5648,5 мянган төгрөгийн зөрүү гарсаныг нягтлаж залруулах.
5. Орон тоо цалингийн санд багтааж зардал гаргах

Аудитаар өгөгдсөн зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 09 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Л.УЛАМБАЯР

Шилүүстэй сумын төсөвт байгууллагуудын 2017 оны үйл ажиллагааны үр дүн

ЗӨВЛӨМЖ

Эрүүл мэндийн төвийн
эрхлэгч их эмч Г.Дашдэмбэрэл-д

Монгол Улсын Ерөнхий аудиторт нийлүүлэх бүтээгдэхүүн ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Шилүүстэй сумын Эрүүл мэндийн төвийн 2017 оны үйл ажиллагааны үр дүнд дүгнэлт өгөх гүйцэтгэлийн аудитаар Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаанд илэрсэн алдаа зөрчилд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

1. Байгууллагын үйл ажиллалгааны төлөвлөгөөнд тусгагдсан хэрэгжээгүй буюу хэрэгжих шатандаа байгаа асуудлуудад дүгнэлт хийж үр дүнг хангуулан ажиллах
2. Авлагыг барагдуулах талаар тодорхой ажил зохион байгуулж бүрэн барагдуулах.
3. Тээвэр шатахууны зардалд шат дараалсан хяналт тавих, багийн эмчийн болон гадны машинаар үйлчлүүлсэн шатахууны зардалд жолоочийн тооцооны хуудас хөтлөж хэвших

Аудитаар өгөгдсөн зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 09 дүгээр сарын 25-ны дотор аймаг дахь Төрийн Аудитын газарт ирүүлнэ үү.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Л.УЛАМБАЯР